




ДУЛААНЫ ГУРАВДУГААР
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК

*Эх орноо хөгжилд хөтлөх
эргийн хүчийг бүтээгнэ*



2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

www.tes3.energy.mn

**БИДНИЙ
ЭРХЭМ ЗОРИЛГО**



*Эх орноо хөгжилд хүргэх
эрчим хүчийг бүтээнэ*

**БИДНИЙ
ХЭТИЙН ЗОРИЛГО**



*Хүний хөгжлийг дээдэлсэн
байгаль орчинд ээлтэй,
дэвшилтэт технологийг
нэвтрүүлсэн, эрчим
хүчний манлайлагч
компани байна.*

АГУУЛГА

| | | |
|------|--|----|
| 1. | КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА | 1 |
| 2. | “ДЦС-3” ТӨХК-ИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ | 2 |
| 3. | ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ | 3 |
| 4. | ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА | 4 |
| 5. | ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ..... | 8 |
| 6. | ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААР | 9 |
| 6.1 | ЦЭХ-ний боловсруулалт, түгээлт | 9 |
| 6.2 | ДЭХ-ний боловсруулалт, түгээлт..... | 9 |
| 6.3 | Жишмэл түлшний талаар | 9 |
| 6.4 | Нийт орлого | 10 |
| 6.5 | Нийт зардал..... | 10 |
| 6.6 | Ашиг алдагдал..... | 11 |
| 6.7 | Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал..... | 11 |
| 6.8 | Нэгжийн өөрийн өртөг | 11 |
| 6.9 | Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт..... | 11 |
| 6.10 | Авлага | 12 |
| 6.11 | Өр төлбөр | 12 |
| 7. | ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ | 13 |
| 8. | ӨВЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ, ИХ ЗАСВАРЫН ТАЛААР | 18 |
| 9. | КОМПАНИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАНГАЛТ, СУРГАЛТ ХӨГЖИЛ | 23 |
| 10. | ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ, ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ АЖИЛ..... | 28 |
| 11. | ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ТАЛААР | 33 |
| 12. | ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКОЛОГИ, БАЙГАЛЬ ОРЧИН | 34 |
| 13. | ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР | 35 |
| 14. | ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР | 42 |
| 15. | ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO 9001:2015 СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР..... | 43 |
| 16. | НИЙГМИЙН АСУУДАЛД ЧИГЛЭСЭН АЖЛУУД..... | 46 |
| 17. | ИЛ ТОД ЁС ЗҮЙН БАЙДАЛ | 47 |
| | КОМПАНИЙН 2021 ОНЫ ОНЦЛОХ ЗҮЙЛ..... | 48 |
| | ДҮГНЭЛТ | 49 |
| | 2022 ОНЫ ЗОРИЛТ..... | 50 |


1. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“ДЦС-3” ТӨХК-ийн дунд даралтын хэсгийн суурийг анх 1966 онд тавьж БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1968 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 136 тоот тогтоолыг үндэслэн “Улаанбаатарын илчит гуравдугаар станц”-ын захиргааг байгуулах тухай шийдвэр гарсан. Дулааны станцын анхны зуух 1968 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ашиглалтанд орсноор нийслэл хотын хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр, 1974 оны 12 сарын 01-ний өдөр анхны турбин генераторыг ашиглалтанд оруулснаар 1975 он гэхэд 45 МВт цахилгаан эрчим хүч, 130 Гкал/ц дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх хүчин чадалтай дулааны цахилгаан станц болсон. ДЦС-ын хүчин чадлыг 1976-1981 онуудад өргөтгөн өндөр даралтын станц баригдаж ашиглалтанд орсноор нийт цахилгаанаар 148 МВт, дулаанаар 485 Гкал/ц суурилагдсан хүчин чадалтай болсон.


“ДЦС-3” ТӨХК-ийн суурилагдсан хүчин чадлыг 2014 онд цахилгаанаар 50 МВт, дулаанаар 100 Гкал/ц-аар нэмэгдүүлснээр станцын хүчин чадал цахилгаанаар 198 МВт, дулаанаар 585 Гкал/ц болсон. Үйл ажиллагааны хувьд: Цахилгаан үйлдвэрлэх, Дулаан үйлдвэрлэх, Дулаан түгээх, Цахилгаанаар зохицуулалттай хангах, Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, Монгол улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээний 18 хувь, Улаанбаатар хотын дулаан хангамжийн 35 хувь, үйлдвэрийн технологийн уурын хэрэглээний 47.5 хувийг ханган ажиллаж байна. Станц нь технологийн хэрэглээний усыг Нисэх, Сонгинын районд байрлах өөрийн худгуудаас, нүүрсийг дан ганц Багануурын уурхайгаас хүлээн авч хэрэглэдэг. Дунд болон өндөр даралтын зуухнуудад хэт ханасан уурыг боловсруулан, турбингенераторт өгч, цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэн 35/110 киловольтын цахилгаан дамжуулах шугамаар төвийн эрчим хүчний систем ба 6 киловольтын шугамаар хэрэглэгчдэд нийлүүлж байна. Дулаацуулгын улиралд Улаанбаатар хотын дулаан хангамжийн системд 7,000 тн усыг халаан өгч байна. Мөн хүнс, ноос ноолуур, арьс шир, барилгын материалын үйлдвэрлэлийн АПУ, Атар өргөө, Витавит инвест, Говь, Улаанбаатар хивс, Кашмир холдинг, Мон ит булигаар, Суурь, Хөнгөн бетон зэрэг 79 үйлдвэр, аж ахуйн газруудыг технологийн уураар ханган ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 164 тоот тогтоолоор 100 хувь Төрийн өмчит хувьцаат компани болон зохион байгуулагдсан.

Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх хувь







2. “ДЦС-3” ТӨХК-ИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



3. ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадал нийт 2021 оны байдлаар 1,523.3 МВт байгаагаас “ДЦС-3” ТӨХК-ийн хүчин чадал 198 МВт буюу 13 хувь, Дулааны цахилгаан станцуудын суурилгдсан хүчин чадал 1,249.8 МВт байгаагаас манай станц 16 хувийг эзэлж байна.



4. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“ДЦС-3” ТӨХК нь 3 алба, 7 хэлтэс, 10 цех, 4 хэсгээс бүрдсэн нэгжийн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Захиргаа, хүний нөөцийн алба

Компанийн өөрчлөлт, хөгжлийн стратегитай уялдсан хүний нөөцийн удирдлагын цогц арга барилыг хэрэгжүүлж манлайллыг бий болгох, ажилтнуудыг сургаж дадлагажуулах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэн хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг сахиулан чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийн хүчээр компанийн тасралтгүй, хэвийн, жигд үйл ажиллагааг хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.

Үйлдвэрлэлийн алба

“Эх орныг хөгжилд хөтлөх эрчим хүчийг бид бүтээнэ” хэмээх эрхэм зорилгыг үндэс болгон цахилгаан дулаан үйлдвэрлэх, хэрэглэгчдийг чанартай эрчим хүчээр тасралтгүй ханган, үйлдвэрлэлийн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх, станцыг эдийн засгийн үр ашигтай горимоор ажиллуулах, ТЭЗҮ-ийг тооцоолох, дээшлүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, тоноглолын горим тохируулгын ажлыг хийж, ашигтай ажиллуулах, цехүүдийн үйл ажиллагааг нэгтгэн удирдах, шуурхай ажиллагааг зөв зохион байгуулах зэрэг ажлуудыг хариуцан ажиллаж байна.

Засвар хяналтын алба

Станцын үндсэн, туслах тоноглолын графикт их ба урсгал засварын ажлын нэгдсэн график гарган мөрдүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж, тоног төхөөрөмжид гарсан их хэмжээний гэмтлийг засварлах ажлын нэгтгэн зохион байгуулж, ашиглалтын хэсэгт хүлээлгэн өгөх ажлыг шуурхай зохион байгуулах үндсэн зорилготой.

Санхүү бүртгэлийн хэлтэс

Компанийн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа бүхий л ажил гүйлгээг санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль, журам, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэж, санхүүгийн тайлан гаргах, жилийн батлагдсан төсөв, төлөвлөгөөний гүйцэтгэлийг гаргаж, судалгаа хийх, гадаад болон дотоодын хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах, компанийн эд хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан үр ашгийг бий болгох үйл ажиллагааг зохион байгуулна.

Төлөвлөлт эдийн засгийн хэлтэс

Компанийн хэтийн болон ойрын бизнес төлөвлөгөөг мөрдөж байгаа норм, судалгаа шинжилгээн дээр үндэслэн бага зардлаар, үр ашигтай ажиллах зарчмыг баримтлан, холбогдох үзүүлэлтүүдээр боловсруулан батлуулж гүйцэтгэлд хяналт тавин, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх, үнэ тарифын санал боловсруулж шийдвэрлүүлэх, хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, орон тоо, цалин хөлсний системийг боловсронгуй болгох, төлөвлөх, холбогдох дүрэм, журмыг боловсруулах, норм нормативыг боловсронгуй болгож, өртөг зардлыг хямдруулах ажил зохион байгуулах, их засвар, урсгал засварын материалын зарцуулалтанд тогтмол хяналт тавих ажлыг зохион байгуулна.

Техник хяналтын хэлтэс

Үйлдвэрлэлийн цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалтын тоноглол, дамжлага, ажлын байруудад хяналт тавих, барилга байгууламжуудыг угсрах, төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм, зааврууд, цахилгаан станц, дулааны шугам сүлжээний дулаан-механикийн тоноглолын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм (ААД) болон эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм (ТАД)-ийг мөрдлөг болгон уг дүрмээр батлагдсан цахилгаан, дулааны тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, химийн горимын биелэлтэнд хяналт тавих, үйлдвэрийн хөдөлмөрийн эрүүл ахуйн норм, стандартын шаардлага хангуулах, хэмжилзүйн дотоод хяналтыг явуулах, Компанийн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Техникийн бодлогын хэлтэс

Эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэл явуулахын тулд нэгж тоноглолын ТЭЗҮ-г дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээг хийж, эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээтэй уялдан суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх болон экологийн сөрөг нөлөөллийг бууруулах техник технологийн шинэчлэл, өөрчлөлтийн бодлогыг үе шаттайгаар боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг бусад алба, хэлтэс, цех нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулна.

Хангамжийн хэлтэс

Харилцагч компаниудтай байнгын холбоотой ажиллаж, гадаад дотоод захиалгыг үндэслэн компанийн хэмжээний бүх төрлийн түлш, шатахуун, материал сэлбэгийн захиалгыг жилийн хэрэгцээгээр хийж, төсөв төлөвлөгөөнд мөрдөж байгаа норм нормативыг үндэслэн тусгаж, жил бүр тогтоосон хугацаанд бэлтгэн нийлүүлэх, гэрээ хэлцэл хийх, дүгнэх, сэлбэг материалын судалгаа гаргаж, үлдэгдлийг хянана.

Горим тооцооны хэлтэс

Үйлдвэрлэлийн найдвартай, үр ашигтай горим төлөвлөх, гүйцэтгэлийг тооцон гаргаж судалгаа, шинжилгээ хийн сайжруулах арга замыг тодорхойлон хэрэгжүүлнэ.

Борлуулалтын хэлтэс

Эрчим хүч хэрэглэгч 100 гаруй үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагатай “Эрчим хүч худалдах, худалдан авах” тухай гэрээ байгуулж эрчим хүчээр ханган, цахилгаан дулааны эрчим хүчний борлуулалтын орлогыг төвлөрүүлнэ.

Үйлчилгээ аж ахуйн хэсэг

Компанийн нийтийн биеийн тамир спорт, соёл, олон нийтийн ажлыг зохион байгуулах, бие бялдрыг хөгжүүлэх спорт, нийгмийн идэвхийг өрнүүлж ажилчдын дунд уралдаан тэмцээн зохиох, ажлын байр болон ахуйн байрнуудын тохижилт, ариун цэвэр, эмх цэгцийг сайжруулах, ажилчдын ажлын хувцсыг цэвэрлэх, ажилчдыг орон сууцжуулах ажлыг зохион байгуулна.

Эмнэлгийн хэсэг

Компанийн ажилтнуудад эмнэлгийн анхан шатны яаралтай тусламж үйлчилгээг үзүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмчилж эрүүлжүүлэх, эрүүл мэндийн сургалт зохион байгуулна.

Автын хэсэг

Тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, засвар үйлчилгээ хийх, шаардлагатай тээврийн хэрэгслээр үйлчилнэ.

Түлш дамжуулах цех

ТДЦ нь уурхайгаас ирсэн нүүрсийг хүлээн авах, нүүрсний тоо, чанарт хяналт тавьж буулгах, нөөцлөх, зуухыг нүүрсээр тасралтгүй хангах үндсэн үүрэгтэй ба цагт 25-30 вагон нүүрс буулгах 2ш вагон хөмрөгч, 180-900 тн/цаг нүүрс дамжуулах хүчин чадалтай 21ш туузан дамжлага, цагт 250-600тн нүүрс бутлах 4ш алхан бутлагч, 275-480тн/цаг чадалтай 6-н займчин тэжээгч, 8ш бульдозер, 170000 тн нүүрснөөцлөх ил талбайгаар тус тус тоноглогдсон.

Дунд даралтын зуухан цех

Одоогийн байдлаар БКЗ-75-39ФБ маркийн 4 зуух, БҮШ-75-39 маркийн 2 зуух болон тэдгээрт хамрах бусад туслах тоноглолуудаар тоноглогдсон. БАА, МАА, солярка АА гэсэн аж ахуйтай үйл ажиллагаагаа явуулж байна. Тус цех нь Түлш дамжуулах цехээс ирсэн нүүрсийг хүлээн авч технологийн боловсруулалтыг хийж, зуухны галын хотолд шатаан нүүрсний шаталтын дулаан энергийг ашиглан 39 ата даралттай, 440 градусын халуунтай хэт халсан уур боловсруулж турбинд цахилгаан, дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх процессыг тасралтгүй хангах үүрэгтэй.

Өндөр даралтын зуухан цех

Тус цех нь Түлш дамжуулах цехээс ирсэн нүүрсийг хүлээн авч технологийн боловсруулалт хийж зуухны галын хотолд шатаан, нүүрсний шаталтын дулааны энергийг ашиглан 100 ата даралттай, 540 градусийн халуунтай усыг боловсруулж хэт халсан уураар турбиныг хангах үүрэгтэй. ӨДЗ Цех нь цагт 100 атмосферийн даралттай 220 тн уур боловсруулах хүчин чадал бүхий БКЗ-220-100-4С маягын 7–н уурын генератор болон тэдгээрт хамаарах бусад туслах тоноглолуудаар тоноглогдсон. Мөн зууханд шатаасан түлш буюу тоосны нүүрсний шаталтын бүтээгдэхүүн болох үнс, шлакийг усаар тээвэрлэн үнсэн санд шахах зориулалттай 900 м3/цаг бүтээмжтэй Грант – 900/67 маркын 3 насос бүхий Багер Аж Ахуй, тээвэрлэгдэн ирсэн үнс, шлакийг үнсэн санд хуримтлуулж, үнс тээвэрлэсэн усны хөдөлгөөнийг нь тайвшруулах замаар тунгааж, тунгаасан усыг эргүүлэн шахах зориулалттай Д –500-65 маркын 4 –н насос бүхий Тунгаагдсан Усны Насос Станц, Мазут нөөцлөх 1000 м3 багтаамжтай 3 бактай, тодорхой даралт температуртай мазутаар зуухыг хангах үүрэг бүхий байнгын ажиллагаатай Мазут Аж Ахуй зэрэг туслах аж ахуйтай.

Дунд даралтын турбин цех

ДДЗ цехийн зууханд боловсруулагдсан хэт халсан уураар турбиныг ажиллуулж цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэгчдийг дулаан цахилгааны эрчим хүчээр тасралтгүй хангах, технологийн хэрэглээний уураар үйлдвэрүүдийг хангах, станцын дотоод хэрэгцээний барилга байгууламжийн хэрэгцээний халуун ус болон дулаацуулгыг тасралтгүй халааж хангах, үйлдвэрлэлийн гарч байгаа бохир болон хаягдал усыг зайлуулах үндсэн үүрэгтэй.

Дунд даралтын турбин цех нь үндсэн тоноглол болох ПТ-12-35/10М маркийн 4ш турбинтай ба 48МВт-ын суурилагдсан хүчин чадалтай. ДДСтанцын дулаанжуулалтын байгууламж нь: үндсэн бойлер – 4ш, туслах бойлер – 2ш, сүлжээний деаэратор – 1ш, хувьсах зарцуулалтын насос – 3ш. Төвлөрсөн дулаан хангамжид 140Гкал/ц-аар хангах суурилагдсан хүчин чадалтай.

Өндөр даралтын турбин цех

“ДЦС-3” ТӨХК-ийн Өндөр Даралтын Турбин Цех нь 1976-1980 оны хооронд станцын IV шатны өргөтгөлөөр Калуга хотын уурын турбины заводод үйлдвэрлэсэн ПТ-25-90/10М загварын 4 турбогенераторыг бусад туслах тоног төхөөрөмжийн хамтаар угсарч ашиглалтанд оруулснаар 2013-2014 онд станцын зургаа дахь шатны өргөтгөлөөр цехийн суурилагдсан хүчин чадлыг БНХАУ-ын “Hunan Industrial Equipment Installation” компанийн С-50/8.83-0.294 маркын турбо генератораар өргөтгөж ӨДТ цехийн суурилагдсан хүчин чадал 150МВт болж нэмэгдсэн.

Цахилгаан цех

Цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх, хуваарилан түгээх үүрэгтэй. Өндөр даралтын хэсгийн генераторын суурилагдсан хүчин чадал 150МВт, Дунд даралтын хэсгийн генераторын суурилагдсан хүчин чадал 48МВт. Станц нь Төвийн эрчим хүчний системтэй 35/110 килоВольтын шугамаар холбогдож 6/35/110 килоВольтын шугамуудаар хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангадаг.

ДХХА цех

Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэхэд шаардлагатай үндсэн ба туслах тоноглолын 450 гаруй цахилгаан хаалт, 300 гаруй халууны хэмжүүр, 1200 гаруй даралт, зарцуулалт, түвшний хэмжүүр, 160 гаруй автомат, регулятор, шибенийн их болон урсгал засварыг графикийн дагуу чанартай хийж, ашиглалтын үед илэрсэн болон гарсан гэмтлүүдийг түргэн шуурхай устган, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль эрх зүйн хүрээнд станцын хэвийн найдвартай эдийн засгийн үр ашигтай ажиллагааг ханган ажиллуулах үндсэн үүрэгтэй.

Хими цех

Техник ашиглалтын дүрмийн шаардлага хангасан давсгүйжүүлсэн, химийн цэвэр болон зөөлөрсөн усаар станцыг тасралтгүй хангаж уур-ус, түлш, тосны чанарын нормыг хангуулах үүрэгтэй. 1 цагт 150 тонн давсгүйжуулсан ус, 120 тонн химийн цэвэр ус, 300 тонн зөөлөрсөн ус боловсруулах хүчин чадалтай.

Засварын Цех

Станцын үндсэн туслах, галын тоноглолын бэлэн байдлыг хангаж, их, урсгал, гэмтэл устгалын засварын ажлыг хийж гүйцэтгэх үндсэн чиг үүрэгтэй ажилладаг.

Механик цех

Бид үндсэн болон туслах тоноглолуудын шаардлагатай металл эд ангиудыг хугацаанд нь чанартай зорж бэлтгэх, кислородоор тасралтгүй хангах, ундны болон цэвэр ус, бохир хаягдлын системийн ажиллагаа, станцын дулаацуулга сантехникийн сүлжээг найдвартай ажиллуулах, өргөх зөөх механизмаар хийгдэх өргөлтийн ажил, хийц бэлдэх сэргээн засварлах үндсэн чиг үүрэгтэй ажилладаг.

Уурын хэсэг

Станцаас гарч байгаа үйлдвэрийн уурыг өөрийн мэдлийн төв болон салбар, салаа шугам сүлжээгээр дамжуулан дулааны эрчим хүч худалдах, хэрэглэгчдийг технологийн уураар тасралтгүй найдвартай хангах үндсэн үүрэгтэй.

5. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ

2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтийг Эрчим хүчний сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байгаад, 2021 оны 4 дүгээр улирлын эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтийг

баталгаажуулж мөрдөн ажилласан.

Хүснэгт 1. 2021 оны ТЭЗҮ, Зорилтот түвшний биелэлт


| Д/д | Эдийн засгийн үндсэн үзүүлэлт | Хэмжих нэгж | 2020 оны гүйцэтгэл | 2021 он | | Өөрчлөлт | | |
|-----|---------------------------------------|----------------|--------------------|------------------|------------------|----------------|---------------|------|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биетээр | Хувиар | |
| 1 | Үйлдвэрлэсэн: Цахилгаан эрчим хүч | сая кВт.ц | 1,050.1 | 1,034.5 | 1,109.2 | 74.7 | 7.2 | |
| | ДХЦЭХ | хувь | 16.86 | 17.11 | 16.37 | -0.74 | -4.3 | |
| | | сая кВт.ц | 177.1 | 177.0 | 181.6 | 4.6 | 2.6 | |
| | Эрчим хүчний түгээлт | ЦЭХ | сая кВт.ц | 873.0 | 857.5 | 927.6 | 70.1 | 8.2 |
| | | ДЭХ | мян.гкал | 2,369.4 | 2,436.5 | 2,466.9 | 30.4 | 1.2 |
| | Үнийн дүнгээр | ЦЭХ | сая.төг | 94,778.4 | 87,008.0 | 97,591.2 | 10,583.2 | 12.2 |
| ДЭХ | | сая.төг | 27,260.4 | 31,391.5 | 30,830.5 | -561.0 | -1.8 | |
| 2 | Нийт орлого | сая.төг | 122,738.5 | 118,992.3 | 128,984.8 | 9,992.5 | 8.4 | |
| | Үүнээс: Цэвэр борлуулалт | сая.төг | 122,038.8 | 118,399.5 | 128,421.7 | 10,022.2 | 8.5 | |
| | ҮАБОрлого | сая.төг | 699.6 | 592.8 | 563.1 | -29.7 | -5.0 | |
| 3 | Нийт зардал | сая.төг | 124,807.9 | 122,467.1 | 128,960.2 | 6,493.1 | 5.3 | |
| | Үүнээс: Удирдлагын зардал | сая.төг | 336.5 | 337.7 | 342.5 | 4.8 | 1.4 | |
| | ҮАБус зардал | сая.төг | 829.1 | 618.3 | 749.7 | 131.4 | 21.3 | |
| 4 | Татварын өмнөх ашиг / алдагдал | сая.төг | (2,069.4) | (3,474.8) | 24.6 | 3,499.3 | -100.7 | |
| 5 | Цэвэр ашиг / алдагдал / | сая.төг | (2,107.6) | (3,474.8) | 23.9 | 3,498.7 | -100.7 | |
| 7 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | төг | 1.02 | 1.03 | 1.00 | -0.03 | -2.9 | |
| 8 | Нийт авлага | сая.төг | 9,713.9 | 7,302.3 | 16,479.8 | 9,177.5 | 125.7 | |
| 9 | Нийт өглөг | сая.төг | 30,494.1 | 29,451.8 | 30,403.2 | 951.4 | 3.2 | |
| | Богино хугацаат өр төлбөр | сая.төг | 10,764.4 | 11,749.0 | 13,151.9 | 1,402.9 | 11.9 | |
| | Урт хугацаат өр төлбөр | сая.төг | 19,729.7 | 17,702.8 | 17,251.2 | -451.6 | -2.6 | |
| 10 | Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт | сая.төг | 21,326.3 | 14,478.9 | 14,195.7 | -283.2 | -2.0 | |
| 11 | Нийт ажиллагсдын тоо | хүн | 995 | 996 | 989 | -7.0 | -0.7 | |
| 12 | Нийт цалингийн сан | сая.төг | 28,432.1 | 28,064.5 | 27,921.3 | -143.2 | -0.5 | |
| 13 | Нэг ажиллагчийн дундаж цалин | мян.төг | 2,381.2 | 2,348.1 | 2,352.6 | 4.5 | 0.2 | |

6. ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААР


6.1 ЦЭХ-ний боловсруулалт, түгээлт

2021 онд 1,109.2 сая кВт.ц цахилгаан эрчим хүч боловсруулснаас дотоод хэрэгцээндээ 181.6 сая кВт.ц буюу 16.37 хувийг зарцуулан 927.6 сая кВт.ц цахилгаан эрчим хүч түгээж, төлөвлөгөөг 108.2 хувиар, диспетчерийн графикийг 100.3 хувиар биелүүллээ.

ДХЦЭХ-ний хэмжээ 2021 онд нийт боловсруулсан ЦЭХ-ний 16.4 хувь буюу 181.6 сая кВт.ц ЦЭХ-ийг дотоод хэрэгцээнд зарцуулсан нь төлөвлөгөөтэй харьцуулахад 0.7 хувиар, өмнөх оноос 0.5 хувиар тус тус буурсан байна.



6.2 ДЭХ-ний боловсруулалт, түгээлт



2021 онд 4,490.3 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэн, уураар 279.1 мян.Гкал, усаар 2,187.8 мян.Гкал, нийт 2,466.9 мян.Гкал дулааны эрчим хүч түгээж төлөвлөгөөг усаар 100.6 хувь, уураар 106.9 хувь, нийт дулаан түгээлтийг 101.2 хувиар биелүүлж ажиллалаа.

6.3 Жишмэл түлшний талаар

Үйлдвэрлэлийн явцад 720.6 мянган тонн жишмэл түлш зарцуулсан нь төлөвлөгөөтэй харьцуулахад 16.3 мянган тонн жишмэл түлш хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь цахилгаан болон дулааны эрчим хүчний үйлдвэрлэл нэмэгдсэнээр цахилгаанд зарцуулах жишмэл түлш 17.9 мянган тонн, дулаанд зарцуулах жишмэл түлш төлөвлөснөөс 4.3 мянган тонноор тус тус нэмэгдсэн.

Нэгж эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшний хувийн зарцуулалт цахилгаанд 310.0 гр/кВт.ц, дулаанд 175.5 кг/Гкал байгаа нь





төлөвлөгөөтэй харьцуулахад цахилгаанд 4.4 гр/кВт.ц-аар, дулаанд 0.4 кг/Гкал-аар тус тус буурсан байна.

ЖТХЗ цахилгаан, дулаанд буурахад ТБЭХС-ийн өсөлттэй холбоотойгоор үндсэн тоноглолын дундаж ачаалал нэмэгдсэнээр дулааны горимоор боловсруулах ЦЭХ нэмэгдсэн болон бууруулан хөргөх төхөөрөмжийн ачаалал болон ДХЦЭХ-ний хэрэглээ буурсан нь гол нөлөө үзүүлсэн.

6.4 Нийт орлого

2021 онд нийт 128,984.8 сая төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөөг 9,992.4 сая төгрөг буюу 8.4 хувиар, өмнөх онтой харьцуулахад 6,246.3 сая төгрөг буюу 5.0 хувиар тус тус тус давуулан биелүүлсэн.

Цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого төлөвлөснөөс 991.4 сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.4 тэрбум төгрөгөөр тус тус өсч, дулааны эрчим хүчний борлуулалтын орлого төлөвлөснөөс 25.5 сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.




Орлого нэмэгдэхэд ТБЭХС-ийн хэрэглээ өссөнтэй холбоотой Нэг худалдан авагчийн загварт бий болсон эерэг үр дүнд ЭХЗХ-ноос батлагдсан БОШХ-ний 5.56 хувь буюу 7,031.0 сая төгрөгийг буцаан тарифт тусгасан нь гол нөлөө үзүүлсэн.

Үндсэн бус үйл ажиллагаанаас 563.1 сая төгрөг орсон нь төлөвлөгөөнөөс 29.7 сая төгрөгөөр буурсан. Энэ нь COVID-19 цар тахлын нөлөөгөөр вагон таталт тавилтын

орлого 18.5 сая төгрөгөөр, түрээсийн орлого 12.0 сая төгрөгөөр тасарсан нь гол нөлөө үзүүлсэн.

6.5 Нийт зардал

2021 онд нийт 128,960.2 сая төгрөгийн зардалтай ажиллаж, төлөвлөсөнөөс 6,493.1 сая төгрөгөөр, өмнөх оноос 4,152.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн. Үндсэн үйл ажиллагаанд 128,210.5 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанд 749.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. ЦЭХ, ДЭХ-ний түгээлт нэмэгдсэнтэй холбоотойгоор түлшний зардал төлөвлөснөөс 4,071.5 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийгдсэнээр



элэгдлийн зардал 3,045.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь зардал хэтрэхэд гол нөлөө үзүүлсэн.

Нийт зардалд түлшний зардал 48.1 хувь, цалингийн зардал 24.5 хувь, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 18.3 хувь, бусад тогтмол зардал 8.4 хувь, үйл ажиллагааны бусад зардал 0.6 хувийг тус тус эзэлж байна.

6.6 Ашиг алдагдал

2021 онд 3,474.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 24.6 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан. Тариф нэмэгдсэнээр нийт орлого төлөвлөснөөс 9,992.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн.

2021 онд ЦЭХ-ний нэгжийн өөрийн өртөг 76.64 төгрөг гарч 1 кВт.ц ЦЭХ-ийг дунджаар 105.2 төгрөгөөр борлуулж, нэгжээс 28.56 төгрөгийн, нийт ЦЭХ-ний үйлдвэрлэлээс 26,501.8 сая төгрөгийн ашигтай ажилласан.

ДЭХ-ний нэгжийн өөрийн өртөг гүйцэтгэлээр 23,155.1 төгрөг гарч 1 Гкал ДЭХ-ийг дунджаар 12,497.7 төгрөгөөр борлуулсан нь нэгжээс 10,657.4 төгрөгийн, нийт ДЭХ үйлдвэрлэлтээс 26,290.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үйл ажиллагааны бус алдагдал гүйцэтгэлээр 186.6 сая төгрөгт хүрсэн.

6.7 Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал

Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардлыг төлөвлөгөөт хэмжээнд барьж, өмнөх оноос 2 мөнгөөр бууруулж ажилласан.

6.8 Нэгжийн өөрийн өртөг

Цахилгаан эрчим хүчний өөрийн өртөг төлөвлөснөөс 1.63 төгрөгөөр буурч, дулааны эрчим хүчний өөрийн өртгийг 688.17 төгрөгөөр нэмэгдсэн.

6.9 Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт

Тус станц нь 2021-2022 оны өвлийн бэлтгэл хангах хүрээнд нийт 5 үндсэн тоноглолд их засвар, 2 үндсэн тоноглолд дунд засвар хийхээр, 117 туслах тоноглолд их засварын ажил хийхээр төлөвлөж 116 тоноглолд их засвар хийгдсэн ба гүйцэтгэл 99.2 хувьтай байна.

ТЗБАХ-ээр 439.6 сая төгрөгийн нийт 6 ажил төлөвлөж, төлөвлөсөн ажлууд бүрэн хийгдэж дууссан. Хөрөнгө оруулалтаар 613.1 сая төгрөгийн 11 багц ажил хийхээр төлөвлөж, төлөвлөсөн ажлууд бүрэн хийгдэж дууссан.


Хүснэгт 2. 2021 оны ИЗ, ТЗБАХ, ХО-ын гүйцэтгэл сая төгрөгөөр

| Тоноглолын нэр | Өмнөх оны гүйц | 2021 он | | Өөрчлөлт | |
|-----------------------------|----------------|------------|-----------|--------------------|-------------------|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | 2021 оны төлөв-өөс | 2020 оны гүйц-ээс |
| Үндсэн тоноглолын их засвар | 5,406.7 | 7,732.4 | 6,379.1 | - 1,353.3 | 972.4 |
| Туслах тоноглолын их засвар | 2,637.5 | 4,931.8 | 3,759.0 | - 1,172.8 | 1,121.4 |
| Барилгын их засвар | 26.2 | 761.8 | 666.6 | - 95.2 | 640.4 |
| ТЗБАХ | 12,433.5 | 439.6 | 2,764.3 | 2,324.7 | - 9,669.2 |
| Хөрөнгө оруулалт | 822.4 | 613.4 | 626.8 | 13.4 | - 195.6 |

6.10 Авлага


2021 оны 12 сард чадлын тарифыг нэмэгдүүлснээр нийт авлага оны эцэст 16,479.8 сая төгрөгт хүрсэн. Үүнд “ДҮТ” ТӨХХК-иас авах авлага 13,882.9 сая төгрөг, татварын авлага 1,406.2 сая төгрөг, жижиг хэрэглэгч хувь хүмүүсээс авах авлага 1,022.8 сая төгрөгийг эзлэж байна.

Нийт авлага /сая төгрөг/



6.11 Өр төлбөр

Нийт өглөг /сая.төг/



2021 онд нийт өр төлбөр 30,403.2 сая төгрөг болж өмнөх оноос 90.9 сая төгрөгөөр буурсан байна.


Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 13,151.9 сая төгрөг болж өмнөх оны мөн үлдэгдлээс 2,387.5 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 17,251.2 сая төгрөгт хүрч өмнөх оноос 2,478.5 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Орон тоо, цалингийн сан

2021 оны байдлаар орон тооны гүйцэтгэлээр 989 гарч 7 орон тоог хэмнэж ажилласан.

Дундаж цалин /мянган.төг/



Цалингийн санд 28,064.5 сая төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 27,921.3 сая төгрөг зарцуулж 143.2 сая төгрөг буюу 0.5 хувиар хэмнэж ажиллалаа.

Ажилтны дундаж цалин гүйцэтгэлээр 2,352.7 мянган төгрөг байгаа нь төлөвлөснөөс 4,551.80 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

7. ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

ЭХЗХ-оос 2021 оны БОШХ-г 126,524.1 сая төгрөгөөр тогтоож үүнээс нэг худалдан авагч дээр үүссэн алдагдлыг тэглэх зорилгоор тарифийг 6.42 хувиар бууруулж 118,399.5 сая төгрөгөөр үйл ажиллагааны орлогын хэмжээг тогтоож 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор “ДҮТ” ТӨХХК-д худалдах цахилгааны тариф, “УБДС” ТӨХК-д худалдах дулааны тарифыг баталсан.

2021 онд Эрчим хүчний зохицуулах хороонд үнэ тарифыг нэмэгдүүлэх талаар нийт 3 удаа албан бичгээр хүсэлт тавьж ажилласан. Үүнд: Их засварын ажлын хүрээнд Зуух №7-13-ын экран хоолой солих ажилд 1,003.0 сая төгрөг, үнсэн сангийн усыг цэвэршүүлэх 150 тн/цагийн бүтээмжтэй байгууламж барих 340.5 сая төгрөг, төслийн нэгжийн үйл ажиллагааны зардал 311.0 сая төгрөгийг үнэ тарифт тусгуулсан.

Ингэснээр ЭХЗХ-ны 2021 оны 10 дугаар 27-ны 480 тоот тушаалаар ЦЭХ-ний чадлын тарифыг 4-р улиралд 3,355.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, “УБДС” ТӨХК-д худалдах дулааны тарифыг Гкал тутамд 1,891.0 төгрөгөөр бууруулж, нийт БОШХэмжээг 1,654.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж өгсөн.

2021 оны 4 дүгээр улиралд Нэг худалдан авагчийн загварт бий болсон эерэг үр дүнд нийт Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тэгш хуваарилах тооцооны хүрээнд тус компанийн оны эхэнд 6.42 хувиар бууруулсан БОШХ-ний 5.56 хувь буюу 7,031.0 сая төгрөгийг буцаан тарифт тусгасан. Ингэснээр 10 дугаар сард шийдвэрлэсэн 1,654.5 сая төгрөг дээр нэмж 5,376.5 сая төгрөгийг 12 дугаар сарын тарифын зохицуулалтаар шийдвэрлэсэн.

Хүснэгт 3. 2021 оны үнэ тарифын зохицуулалт

| Тариф | хэмжих нэгж | 2020 оны тариф | 2021 оны тариф | 2021.10.27-ны өдрийн өөрчлөлт | 2021.12.27-ны өдрийн өөрчлөлт | Өөрчлөлт | |
|--|-------------|----------------|----------------|-------------------------------|-------------------------------|-------------------|------------------------------------|
| | | | | | | 2021 оны тарифаас | 2021 оны 10 сард орсон өөрчлөлтөөс |
| ДҮТ-д худалдах цахилгааны тариф | | | | | | | |
| Энергийн тариф | төг/кВт.ц | 42.98 | 42.81 | 42.81 | 42.81 | - | - |
| Чадлын тариф | | | | | | | |
| 1 дүгээр улирал | м.төг/сар | 6,086,338 | 5,222,074 | 5,222,074 | 5,222,074 | - | - |
| 2 дугаар улирал | м.төг/сар | 3,580,199 | 2,884,033 | 2,884,033 | 2,884,033 | - | - |
| 3 дугаар улирал | м.төг/сар | 3,740,139 | 2,884,033 | 2,884,033 | 2,884,033 | - | - |
| 4 дүгээр улирал | м.төг/сар | 5,049,904 | 5,222,074 | 6,340,647 | 10,761,391 | 5,539,317.0 | 4,420,744.0 |
| УБДС-д худалдах дулааны тариф | | | | | | | |
| 1 дүгээр улирал | төг/Гкал | 12,000 | 12,000 | 12,000 | 12,000 | - | - |
| 2 дугаар улирал | төг/Гкал | 14,110 | 14,110 | 14,110 | 14,110 | - | - |
| 3 дугаар улирал | төг/Гкал | 3,000 | 4,907 | 4,907 | 4,907 | - | - |
| 4 дүгээр улирал | төг/Гкал | 8,744 | 11,843 | 9,952 | 12,481 | 637.9 | 2,528.9 |

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

| Үзүүлэлт | 2021.01.01 | 2021.12.31 |
|---------------------------------------|----------------------|----------------------|
| Хөрөнгө | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 1,032,067.5 | 2,750,076.0 |
| Дансны авлага | 8,716,333.2 | 14,841,687.7 |
| Татвар, НДШ-ийн авлага | 884,576.9 | 1,574,099.3 |
| Бусад авлага | 112,954.4 | 63,973.3 |
| Бараа материал | 9,377,755.9 | 10,947,076.5 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 1,081,654.8 | 442,014.4 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 21,205,342.8 | 30,618,927.2 |
| Үндсэн хөрөнгө | 225,691,789.2 | 229,004,522.1 |
| Биет бус хөрөнгө | 39,095,674.6 | 39,033,550.9 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | 204,765.2 | 204,765.2 |
| Дуусаагүй барилга | 12,782,891.5 | 69,365.3 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 277,775,120.4 | 268,312,203.6 |
| Нийт хөрөнгийн дүн | 298,980,463.2 | 298,931,130.7 |
| Өр төлбөр | | |
| Дансны өглөг | 1,187,455.0 | 8,651,931.7 |
| Цалингийн өглөг | 2,928,119.1 | 2,826,977.6 |
| Татварын өр | 148,945.7 | 471,451.6 |
| Богино хугацаат зээл | 5,778,140.8 | 848,662.4 |
| Хүүний өглөг | 150,742.9 | 146,117.2 |
| Урьдчилж орсон орлого | 276,688.5 | 7,670.9 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 294,344.0 | 199,133.6 |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 10,764,436.0 | 13,151,944.9 |
| Урт хугацаат зээл | 15,267,147.2 | 13,489,006.7 |
| Хойшлогдсон татварын өр | 1,720,580.9 | 1,396,255.8 |
| Бусад урт хугацаат өр төлбөр | 2,741,954.6 | 2,365,960.1 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | 19,729,682.7 | 17,251,222.6 |
| Өр төлбөрийн нийт дүн | 30,494,118.7 | 30,403,167.5 |
| Эзэмшигчийн өмч | | |
| Өмч: - төрийн | 99,362,783.0 | 99,362,782.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 158,066,844.1 | 157,971,926.5 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 38,753,450.0 | 38,753,450 |
| Хуримтлагдсан ашиг | (27,696,732.6) | (27,560,196.3) |
| Тайлангийн үеийн ашиг | (2,107,609.5) | 23,962.2 |
| Өмнөх үеийн ашиг | (25,589,123.1) | (27,584,158.4) |
| Эздийн өмчийн дүн | 268,486,344.5 | 268,527,963.2 |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 298,980,463.2 | 298,931,130.7 |

ОРЛОГЫН ТАЙЛАН

| Үзүүлэлт | 2020.12.31 | 2021.12.31 |
|--|---------------|---------------|
| Борлуулалтын орлого (цэвэр) | 122,038,838.3 | 128,421,637.3 |
| Борлуулалтын өртөг | 113,936,670.3 | 118,184,413.8 |
| Нийт ашиг(алдагдал) | 8,102,168.0 | 10,237,223.5 |
| Түрээсийн орлого | 105,148.7 | 88,972.4 |
| Хүүний орлого | 52,710.4 | 5,884.4 |
| Ногдол ашгийн орлого | - | - |
| Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| Бусад орлого | 515,458.9 | 468,274.0 |
| Орлогын дүн | 673,318.0 | 563,130.8 |
| Борлуулалт, маркетингийн зардал | 195,737.2 | 197,666.1 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 7,677,493.5 | 7,683,270.7 |
| Санхүүгийн зардал | 694,858.8 | 515,611.9 |
| Бусад зардал | 2,279,024.7 | 2,379,253.5 |
| Зардлын дүн | 10,847,114.3 | 10,775,802.3 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 23,524.9 | -1.5 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | (21,331.3) | - |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | - | - |
| Бусад ашиг (алдагдал) | - | - |
| Олз, гарзын дүн | 2,193.6 | -1.5 |
| Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал) | (2,069,434.7) | 24,550.6 |
| Орлогын татварын зардал | 38,174.8 | 588.4 |
| Татварын дараах ашиг (алдагдал) | (2,107,609.5) | 23,962.2 |
| Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал) | - | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (2,107,609.5) | 23,962.2 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| Бусад олз (гарз) | - | - |
| Орлогын нийт дүн | - | - |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | - |

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Үзүүлэлт | Өмч | Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдс ан ашиг | Нийт дүн |
|--|---------------------|---------------------------------------|---------------------------------|------------------------|----------------------|
| 2019 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл | 99,362,783.0 | 109,442,769.3 | 38,694,650.0 | -25,869,711.8 | 221,630,490.4 |
| НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.0 | 0.0 | 0.0 | 280,588.7 | 280,588.7 |
| Залруулсан үлдэгдэл | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.0 | 0.0 | 0.0 | -2,107,609.5 | -2,107,609.5 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0.0 | 0.0 | 58,800.0 | 0.0 | 58,800.0 |
| Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.0 | 48,624,074.8 | 0.0 | 0.0 | 48,624,074.8 |
| 2020 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл | 99,362,783.0 | 158,066,844.1 | 38,753,450.0 | -27,696,732.6 | 268,486,344.5 |
| НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.0 | 0.0 | 0.0 | 112,574.2 | 112,574.2 |
| Залруулсан үлдэгдэл | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.0 | 0.0 | 0.0 | 23,962.2 | 23,962.2 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.0 | -94,917.7 | 0.0 | 0.0 | -94,917.7 |
| 2021 оын 12 сарын 31-р үлдэгдэл | 99,362,783.0 | 157,971,926.5 | 38,753,450.0 | -27,560,196.3 | 268,527,963.2 |

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН


| Үзүүлэлт | 2020.12.31 | 2021.12.31 |
|--|--------------------|--------------------|
| 1.Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ | - | - |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| Мөнгөн орлогын дүн (+) | 124,131,048.4 | 125,404,661.6 |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 123,806,909.5 | 124,902,279.6 |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | - |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 204,968.2 | 304,022.1 |
| Буцаан авсан албан татвар | - | - |
| Татаас, санхүүжилтийн орлого | - | - |
| Бусад мөнгөн орлого | 119,170.8 | 198,359.9 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 111,375,816.0 | 111,885,707.2 |
| Ажиллагчдад төлсөн | 21,875,811.5 | 23,611,647.5 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 7,172,061.3 | 7,892,000 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 60,570,547.6 | 59,690,029.9 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 2,195,818.2 | 1,611,968.2 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн | 8,975,724.1 | 6,457,599.1 |
| Хүүний төлбөрт төлсөн | 401,839.4 | 201,049.2 |
| Татварын байгууллагад төлсөн | 8,401,826.5 | 10,212,859.6 |
| Даатгалын төлбөрт төлсөн | 76,839.9 | 51,407.9 |
| Бусад мөнгөн зарлага | 1,705,347.5 | 2,157,145.8 |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 12,755,232.4 | 13,518,954.4 |
| 2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| Мөнгөн орлогын дүн (+) | 52,710.4 | 5,884.4 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| Биет бус хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | - | - |
| Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | - |
| Хүлээн авсан хүүний орлого | 52,710.4 | 5,884.4 |
| Хүлээн авсан ногдол ашиг | - | - |
| Бусад | - | - |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 16,715,097.1 | 7,541,069.9 |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 16,715,097.1 | 7,541,069.9 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | - | - |
| Бусад | - | - |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (16,662,386.7) | (7,535,185.5) |
| 1. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| Мөнгөн орлогын дүн (+) | 5,000,000.0 | - |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 5,000,000.0 | - |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| Төрөл бүрийн хандив | - | - |
| Бусад | - | - |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 1,213,415.2 | 4,265,760.4 |
| Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 1,213,415.2 | 4,265,760.4 |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | - | - |
| Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | - | - |
| Төлсөн ногдол ашиг | - | - |
| Бусад | - | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 3,786,584.8 | (4,265,760.4) |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (120,569.5) | 1,718,008.5 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,152,637.0 | 1,032,067.5 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,032,067.5 | 2,750,076.0 |

САНХҮҮГИЙН ХАРЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

| Үзүүлэлт | Харьцаа | 2018 оны IV улирал | 2019 оны IV улирал | 2020 оны IV улирал | 2021 оны IV улирал |
|---|---|--------------------|--------------------|--------------------|--------------------|
| Эргэлтийн хөрөнгийн харьцаа | Эргэлтийн хөрөнгө / нийт хөрөнгө | 0.081 | 0.104 | 0.071 | 0.102 |
| Нөхөлтийн коэффициент | Эргэлтийн хөрөнгө / богино хугацаат өр | 2.532 | 2.170 | 1.970 | 2.328 |
| Биет хөрөнгийн хувийн жин | Биет хөрөнгө / нийт хөрөнгө | 76.52% | 74.22% | 75.49% | 76.61% |
| Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа | ЭХ-бараа материал / богино хугацаат өр | 1.286 | 1.198 | 1.099 | 1.496 |
| Эргэлтийн гаднах хөрөнгө | Авлага / нийт хөрөнгө | 0.073 | 0.033 | 0.032 | 0.055 |
| Авлага цуглуулах дундаж хугацаа | Авлага*360 хоног / борлуулалт | 59.793 | 26.601 | 28.655 | 46.197 |
| Төлбөр төлөх дундаж хугацаа | Дансны өр*360 хоног / худалдан авалт | 18.186 | 63.567 | 6.147 | 47.087 |
| Бараа материалын эргэц | ББӨӨ / бараа материалын нөөц | 10.115 | 9.173 | 12.150 | 10.796 |
| Өрийн харьцаа | Нийт өр / нийт хөрөнгө | 0.125 | 0.133 | 0.102 | 0.102 |
| Өр хөрөнгийн харьцаа | Урт хугацаат өр / эзэмшигчийн өмч | 0.107 | 0.099 | 0.073 | 0.064 |
| Урт хугацаат өр, нийт хөрөнгийн харьцаа | Урт хугацаат өр / нийт хөрөнгө | 0.093 | 0.085 | 0.066 | 0.058 |
| Ажлын капитал /ЦЭХ/сая төгрөг | Эргэлтийн хөрөнгө - богино хугацаат өр | 12616.8 | 14283.7 | 10440.9 | 17467.0 |
| Өөрийн эргэлтийн капитал сая төгрөг | Авлага + материалын нөөц – богино хугацаат өр | 20646.5 | 8225.3 | 8327.2 | 14274.9 |
| Мөнгөний эргэлт | Борлуулалт / ажлын капитал | 8.884 | 8.113 | 11.689 | 7.352 |
| Биет хөрөнгө, эзний өмчийн харьцаа | Биет хөрөнгө / эзний өмч | 0.875 | 0.856 | 0.841 | 0.853 |
| Хөрөнгийн ачаалал | Борлуулалт / нийт хөрөнгө | 0.437 | 0.453 | 0.408 | 0.430 |
| Капитал өгөөж | Борлуулалт / үндсэн хөрөнгө | 0.571 | 0.611 | 0.541 | 0.561 |
| Санхүүгийн хараат байдал | Нийт эх үүсвэр / эзний өмч | 1.143 | 1.154 | 1.114 | 1.113 |
| Хөдөлмөрийн бүтээмж | Борлуулалт / ажиллагсдын тоо | 112.884 | 116.580 | 122.652 | 129.850 |

Компани 2021 оны байдлаар өөрийн богино хугацаат өр төлбөрөө барагдуулах чадвартай, эргэлтийн харьцаа сайжирсан үзүүлэлттэй байна. Ажлын капитал нэмэгдсэнтэй холбоотой хөрвөх чадварын үзүүлэлтүүд сайжирчээ. Үйл ажиллагааны шинжилгээний хувьд авч үзэхэд авлага нэмэгдсэнтэй холбоотой авлага цуглуулах болон төлбөр төлөх хугацаа нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Өрийн харьцаа өмнөх оны үзүүлэлттэй ижил түвшинд буюу нийт хөрөнгийн 10.2 хувиар өрөөр санхүүжиж байна. Орлого нэмэгдсэнтэй холбоотой ашгийн харьцааны үзүүлэлт сайжирсан ба цаашид орлого төвлөрүүлэлтийг сайжруулах, авлага болон өр төлбөрийн хэмжээг бууруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

8. ӨВЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ, ИХ ЗАСВАРЫН ТАЛААР



2021 онд нийт 5 үндсэн тоноглолд их засвар, 2 үндсэн тоноглолд дунд засвар, 117 туслах тоноглолд их засварын ажил хийхээр төлөвлөж 116 тоноглолд их засвар хийгдэж, гүйцэтгэгч материал нийлүүлээгүйгээс 1 ажил хийгдээгүй. Их засварын гүйцэтгэл 99.2 хувьтай байна. Хойшилсон ажил: ТГ-6-н тэжээлийн усны шугам солих ажил хийгдээгүй. Бутлагчийн алх цутгуулах ажил гүйцэтгэгч амжилтгүй болсон тул засварын ажил дутуу хийгдсэн.

Засварын бэлтгэл хангах ажлын хүрээнд хийгдсэн ажил

2021 оны төлөвлөгдсөн засварын ажлуудыг гүйцэтгэхийн тулд засварын улирал хүртэл бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн. Үүнд:

- 2021 онд их засвар хийгдэх үндсэн тоноглолуудын ажлын цар хүрээ эзлэхүүнийг тодотгох, ажлын эзэлхүүнд тодотгол хийх.
- Их засварт шаардлагатай жижиг хийцүүдийг их засвар эхлэхээс өмнө Механик цехийн хийцийн хэсгээр хийлгэж бэлтгэх
- Их засварын гүйцэтгэгч шалгаруулах тендерийн материал бэлтгэх, зарлах, шалгаруулалт явуулах, гүйцэтгэгч сонгон шалгаруулалт хийх
- Засварын ажилд шаардлагатай багаж хэрэгсэл, татлага, тэнжээ, өргөх зөөх төхөөрөмжүүд, металл судлалын лабораторын хэмжих шалгах багаж, дулаан боловсруулалтын аппаратын бэлэн байдлыг хангах, баталгаажуулах
- Их засварын ажлын гүйцэтгэгчдийг байрлуулах ахуйн байр бэлтгэх
- Токарийн суурь машинуудын засварын ажлыг гүйцэтгүүлж их засварын ажил эхлэхийн өмнө бэлэн байдлыг хангасан байх
- Агуулахад байгаа материал, сэлбэгийн бэлэн байдалд үзлэг хийж түүнтэй уялдуулан их засвар хийх тоноглолоо сонгох.
- Станцын бүрэн зогсолтын ажлын эзэлхүүнийг урьдчилан гаргаж график хийж баталгаажуулах, хүн хүч, багаж хэрэгсэлийн жагсаалт гаргаж хуваарилан бэлдэх гэх мэтийн ажлууд хийгдсэн.

Их засварын ажил 2021 онд өвлийн бэлтгэл хангаж 5 үндсэн тоноглолд их засвар, 2 үндсэн тоноглолд дунд засвар, 117 туслах тоноглолд их засвар хийхээр төлөвлөсөн.

Хүснэгт 4. 2021 оны үндсэн тоноглолын их засварын гүйцэтгэл сая төгрөгөөр

| № | Хийгдэх ажил | Тоо хэмжээ | Төлөвлөсөн хөрөнгө /сая.төг/ | Зарцуулсан хөрөнгө /сая.төг/ | Гүйцэтгэл /хувь/ | Тайлбар |
|------------------------------------|---|------------|------------------------------|------------------------------|------------------|---|
| ҮНДСЭН ТОНОГЛОЛЫН ИХ ЗАСВАР | | | | | | |
| 1 | Зуух №1 их засвар | 1 тоноглол | 925.4 | 802.4 | 100 | ТАД-ийн дагуу графикт их засварыг технологийн дагуу хийснээр үндсэн тоноглолын найдвартай ажиллагааг дээшлүүлсэн. |
| 2 | Зуух №7 тоосон системийн их засвар | 1 тоноглол | 1,223.8 | 1,117.1 | 100 | |
| 3 | Зуух №13 их засвар | 1 тоноглол | 2,248.5 | 2,018.9 | 100 | |
| 4 | Зуух № 3 нэмэлт халах гадаргуу солих | 1 тоноглол | 80.7 | 68.3 | 100 | Найдвартай ажиллагааг дээшлүүлж тоноглолын бэлэн байдлыг хангасан. |
| 5 | Зуух № 4 нэмэлт халах гадаргуу, сопло солих | 1 тоноглол | 178.7 | 136.2 | 100 | |

| | | | | | | |
|------------------------------------|------------------------------|--------------|----------------|----------------|------------|---|
| 6 | Турбингенератор №1 их засвар | 1 тоноглол | 893.3 | 819.3 | 100 | |
| 7 | Турбингенератор №6 их засвар | 1 тоноглол | 1,178.7 | 1,145.0 | 100 | ТАД-ийн дагуу графикт их засварыг технологийн дагуу хийснээр үндсэн тоноглолын найдвартай ажиллагааг дээшлүүлсэн. |
| НИЙТ ДҮН | | | 6,729.4 | 6,107.4 | 100 | |
| ТУСЛАХ ТОНОГЛОЛЫН ИХ ЗАСВАР | | | | | | |
| 1 | Туслах тоноглолын их засвар | 117 тоноглол | 4,931.6 | 3,758.9 | 99.2 | Туслах тоноглолуудад технологийн дагуу их засвар хийж тоноглолын бэлэн байдлыг хангасан. |

Нийт 117 туслах тоноглолд их засвар хийхээр төлөвлөснөөс 116 ажлыг хийж дууссан. Турбингенератор №6-ийн тэжээлийн усны шугам солих ажил хийгдээгүй. Цар тахлын улмаас хил хаасантай холбоотой солигдох шугам хоолой, булангууд орж ирээгүй.

ТЗБАХ-ний ажил

Нийт 6 ажил төлөвлөсөн. Гүйцэтгэл – 90.0 хувь

Хүснэгт 5. 2021 оны ТЗБАХ-ний ажлын гүйцэтгэл сая төгрөгөөр

| № | Хийгдэх ажил | Тоо хэмжээ | Төлөвлөсөн хөрөнгө /сая.тө/ | Зарцуулсан хөрөнгө /сая.тө/ | Гүйцэтгэл /хувь/ | Тайлбар |
|----------------------------|--|------------|-----------------------------|-----------------------------|------------------|--|
| 1 | ТГ-5,6,7,8 генераторын гүйдлийн трансфоматор, тоолуур шинээр тавьж монтажлах | 1 багц | 44.4 | - | 50.0 | Гэрээ байгуулсан. Бараа материал татан авах ажил хил хаагдсанаас болж удааширсан. |
| 2 | ӨДХ К№7,13-н хяналтын программ хангамж, контроллер солих | 1 багц | 33.0 | 33.0 | 100.0 | Монтажийн ажил хийгдэж дууссан, шалгаж тохируулах ажил хийгдэж байгаа. |
| 3 | Гүүрэн крануудын үндсэн болон туслах дэгээнүүд | 6ш | 15.8 | 14.4 | 100.0 | ДДЗуухан цех, ДДТурбин цех, ӨДЗуухан цехийн №2 болон утаа сорогчийн эгнээний гүүрэн крануудын дэгээ шинэчилсэн. |
| 4 | Үйлдвэрийн уурын түр шугамын зураг хийлгэх | 1 багц | 30.6 | 30.6 | 100.0 | Зураг төсөв хийлгэж гэрээ дүгнэсэн. |
| 5 | Тунгаах усны шугаманд зарцуулалтын хэмжүүр суурилуулах | 1 багц | 6.32 | - | 100.0 | Зарцуулалтын хэмжүүрийг захиалан авсан. |
| НИЙТ ДҮН | | | 130.1 | 78.0 | 90.0 | |
| Тодотголоор нэмэгдсэн ажил | | | | | | |
| 6 | Үнсэн сангийн усыг цэвэршүүлэх 150 т/ц бүтээмжтэй цэвэрлэх байгууламж барих | 1 багц | 309.5 | - | 100.0 | Барилга барих, хаягдлын худаг хийх, хаалт арматур суурилуулах ажлууд хийгдсэн. Цэвэршүүлэх тоног төхөөрөмж хил дээр гацсанаас ажил удааширсан. |

Хөрөнгө оруулалтын ажил

Хүснэгт 6. 2021 оны Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл сая төгрөгөөр

| № | Хийгдэх ажил | Тоо хэмжээ | Төлөвлөсөн хөрөнгө /сая.төг/ | Зарцуулсан хөрөнгө /сая.төг/ | Гүйцэтгэл /хувь/ | Тайлбар |
|-----------------------------|--|------------|------------------------------|------------------------------|------------------|--|
| 1 | Вагон пүүний программ | 1 багц | 19.8 | 19.8 | 100.0 | Программын ажиллагаа, компьютер техник хангамж сайжирч найдвартай ажиллагаа дээшилсэн. |
| 2 | Тээрмийн салхилуурын ажлын хүрээнд керамик хамгаалалт хийх элэгдэлд тэсвэртэй плита, цавуу | 1 багц | 29.8 | 27.5 | 100.0 | Тоноглолын найдвартай ажиллагаа дээшилсэн. |
| 3 | XLPE тусгаарлагатай кабель турших нам давтамжийн генератор | 1 ш | 30.7 | 30.7 | 100.0 | Станцад ашиглагдаж байгаа XLPE тусгаарлагатай кабелиудын гэмтлийг эрт үед тодорхойлох боломжтой. |
| 4 | ДДС-ын Т2-12-2 турбогенераторын ВТ-75-300 өдөөгч | 1 ш | 88.2 | 88.2 | 100.0 | ТГ №4 бэлтгэл өдөөгчөөр ажиллаж ДХЦЭХ-ийг нэмэгдүүлж байсан. Хэрэглэгчийг эрчим хүчээр найдвартай хангах боломж бүрдсэн. |
| 5 | К төрлийн лабораторийн эталон датчик /0-1100°C/. SPRT стандартад нийцсэн байх. | 1ш | 9.1 | 9.1 | 100.0 | К төрлийн эталон датчикийг ашигласнаар өөрсдөө датчикуудаа шалгах бүрэн боломжтой болж |
| 6 | Пуужин халаагч 380В цахилгаан | 1 ком | 4.5 | 4.5 | 100.0 | Засварын ажил чанартай хийгдэх, цаг хугацаа хэмнэх боломж бүрдсэн. |
| 7 | Усны цахилгаан дамжуулах чадвар хэмжигч /суурин/ | 1ш | 4.0 | | 100.0 | Ус бэлтгэлийн найдвартай ажиллагаа, горим барилтын хяналт дээшилсэн. |
| 8 | Барилгын төсвийн програм /estimator/ | 1 багц | 0.8 | 0.8 | 100.0 | Программ ашигладаг болсноор төсөв хийх цаг хугацаа хэмнэж ажлын бүтээмж дээшилсэн. |
| 9 | Авто кран ОУ25V531 /Zoomlion/ | 1ш | 358.2 | 357.3 | 100.0 | Станцын үйл ажиллагааны техникийн бэлэн байдлыг хангасан. автокран авсанаар хүчин чадал нэмэгдэж бүтээмж дээшилж ашиглалтын зардал буурсан |
| НИЙТ ДҮН | | | 545.1 | 537.9 | 100.0 | |
| Тодотголоор нэмэгдсэн ажил: | | | | | | |
| 10 | Хөдөлгүүр ДАЗО4-400-АУ, 500кВт, | 1ш | 45.4 | - | 100.0 | Гэрээ байгуулж тоног төхөөрөмж хил дээр гацсанаас ажил удааширсан. |
| 11 | Хөдөлгүүр АИР355S6УЗ, 160 кВт, 980 об/мин | 1ш | 22.7 | - | 100.0 | |

ТЗБАХ, Хөрөнгө оруулалтаар хийсэн ажлын үр дүн, эдийн засгийн үр ашиг

- ДДЗ цехийн үндсэн тоноглолын галлагаа, зогсолтын тоог 9 удаа, ӨДЗ цехийн зуухны тээрмийн салхилуурын ажлын хүрзэм солих ажлыг 14-р бууруулсанаар **72.2** сая төгрөг;
- Вагон пүүний программ шинэчилсэнээр 1,061 тонн нүүрс буюу **35.5** сая төгрөг;
- Дотоод хэрэгцээний 980.0 мянган кВт.ц буюу **137.8** сая төгрөгийн хэмнэлтийг тус тус гаргаж нийт 245.5 сая төгрөгийн хэмнэлт гаргасан.
- Үйлдвэрийн уурын түр шугам татсанаар 19 хэрэглэгчийг 88.7 ГДж, **614.2** сая төгрөгийн уурын борлуулалтыг түгээх нөхцөл бүрдсэн.


ДДС-ын ТГ-4 үндсэн өдөөгчийн ВТ-75-300 якорыг шинээр сольж шинэчлэх ажил

1968 онд тавигдсан Якорын пластинк нимгэрч ашиглах боломжгүй болж, оч хаяж эхэлснээс 2020 оны 10-р сарын 02-ний өдрийн 10 цагаас бэлтгэл өдөөгчид шилжүүлж, бэлтгэл өдөөгчөөр нийт 168 өдөр нийт 4,032 цаг ажиллсан. ТГ-4 үндсэн өдөөгчийн якорыг шинээр авч тавьснаар 2021-09-01 өдрөөс 2021-12-14 хүртэл ажилд явсан бөгөөд нийт 2,455 цаг ажиллаж 980.0 мянган кВт.ц буюу 137.8 сая төг хэмнэж ажилласан байна.

XLPE тусгаарлагчтай кабель турших нам давтамжийн генератор суурилуулах ажил

Уг төхөөрөмж нь хамгийн орчин үеийн дижитал хувьсах давтамжийн технологийг, компьютерийн бичил хяналтын системийн хамт хослуулсан тул хүчдэл автоматаар нэмэгдэх, буурах, хэмжилт хийх, хамгаалах болон хүчдэл автоматаар нэмэгдэх үйл явцыг гар аргаар зогсоох гэх мэт үйлдлийг таних чадвартай. Төхөөрөмж нь бүхэлдээ электрон загвартай учраас овор хэмжээний хувьд бага, мөн жингийн хувьд хөнгөн байдаг. Том LCD дэлгэц нь илүү тод, сайн харах боломжийг олгож гаралтын долгионы хэлбэрийг сайн харуулж өгдөг мөн туршилтын тайланг хэвлэх боломжтой бүрэн автоматжуулсан төхөөрөмж юм. Энэхүү төрөөмжийг суурилуулснаар манай станцад ашиглагдаж байгаа XLPE тусгаарлагатай кабелиудын гэмтлийг эрт үед тодорхойлох боломжтой. Гэмтлийг эрт үед тодорхойлсноор тоноглолын найдвартай ажиллагаа дээшилж, гэмтлийн тоо 10 хувь хүртэл буурах боломжтой болсон.

Үйлдвэрийн уурын түр шугамын зураг хийлгэх ажил:



Дэлхийн банкнаас санхүүжиж буй сүлжээний 5а магистраль шугамын өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдэх боломжгүй болно. Уурын хэрэглэгчдийг технологийн уураар тасралтгүй, найдвартай хангах боломжгүй болсон тул үйлдвэрийн уураар хангах түр шугамын ажил хийгдэх шаардлага үүссэн. Энэхүү ажил хийгдсэнээр Сүлжээний 5а магистраль шугамын өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдэх боломжтой болж 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд 5а чиглэлийн уурын шугамаас тэжээгддэг нийт 19 хэрэглэгчийг уураар тасралтгүй хангах, 88.7 ГДж, 614.2 сая төгрөгийн үйлдвэрийн уурыг түгээх нөхцөл бүрдсэн. Зураг, төсвийн дагуу түр шугам татах ажлын хөрөнгийг Дэлхийн банкны санхүүжилтэнд нэмж тусгуулж хийлгэсэн.

Вагон пүүний программ шинэчлэх ажил

ТДЦ-ийн Вагон пүү 2004 оны 09-р сарын 30-ны өдөр анх суурилагдаж вагон пүүлж эхэлсэн. Ашиглалтанд орсноос хойш шинэчлэлт засварын ажил хийгдээгүй байсан. Вагон пүүг тавигдахаас өмнө Багануурын уурхайтай вагон даацаар нүүрсний тооцоог нийлдэг байсан. Вагон пүүг тавигдснаас хойш Багануурын уурхай болон станцын хоорондын пүүний дундаж жингээр тооцоо нийлдэг байсан нь жингийн зөрүү 1.5 хувиас дээш заадаг байсан. Вагон пүүний программ зөвшөөрөгдөх хэмжээнд заадаг байсан боловч пүүний программ ачаалах, функц хүлээж авах чадвар нь муудсанаар жингийн зөрүү гарах шалтгаан болж байсан. 2021 онд программ шинэчилсэн.

Вагон пүүний программ шинэчилснээр 2021 оны 07-р сарын 01-ний өдрөөс одоо хүртэл Багануурын уурхайн дундаж жин 65.67 болон станцын дундаж жин 65.85 болж хоёр байгууллагын хоорондох жин 0.18 болж ойртсон. Вагон пүүний программ шинэчилсний дараа уурхайгаас ирж байгаа нүүрснээс 1,061 тн буюу 35.5 сая төгрөг хэмнэсэн.

ӨДХ КN№7,13-н хяналтын программ хангамж, контроллер солих ажил

К-7,13-ын MOD30 болон ICPDAS i7000 серийн модулиудаас мэдээлэл татах хурд үйлдлийн системийн солигдсонтой холбоотой удаан болсон. АBB AC400 PLC контроллер сэлбэг, программ хангамжийг өөрчлөх боломжгүй, овор ихтэй, сэлбэг олдохгүй байсан тул шинэчилсэн.

Үндсэн тоноглолын найдвартай ажиллагаа дээшилж гэмтлийн тоо буурна. Хяналтын программ нь сүүлийн үеийн хүчин чадалтай котпьютерүүд дээр ажиллах бүрэн боломжтой Win10 үйлдлийн систем дээр бичигдсэн, овор хэмжээ багатай засвар үйлчилгээ хийх бүрэн боломжтой нөхцлөөр хангагдсан давуу талтай.

Тээрмийн салхилуурын ажлын хүрээнд керамик хамгаалалт хийх элэгдэлд тэсвэртэй плита, цавуу худалдаж авах ажил


Тээрмийн салхилуурын ажлын хүрээнд керамик бүрэлтгүй үед элэгдэлд орж зуухны тасралтгүй ажиллах хугацаа 1,500 цаг, тээрмийн салхилуурт 2 долоо хоногт 1 удаа тогтмол үзлэг хийж ажилладаг байсан. Иймд тоноглолын ажлын хүрээнд элэгдэлд тэсвэртэй керамик хамгаалалт хийх шаардлага гарсан. Тээрмийн салхилуурын ажлын хүрээнийг элэгдэлд тэсвэртэй болгосноор үндсэн тоноглолын тасралтгүй ажиллах цаг 5,000-7,000 цаг болж тээрмийн салхилуурын ажлын хүрээний элэгдлээс шалтгаалсан зогсолтын тоо 9 удаа, тээрмийн салхилуурын ажлын хүрээнд солих ажил 14-р буурсан нь станцын тасралтгүй, найдвартай ажиллагаанд сайнаар нөлөөлсөн.

9. КОМПАНИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАНГАЛТ, СУРГАЛТ ХӨГЖИЛ

2021 онд компанийн өөрчлөлт, хөгжлийн стратегитай уялдсан хүний нөөцийн удирдлагын цогц арга барилыг хэрэгжүүлэх, ажилчдын нийгмийн баталгааг хангах, тэднийг сургаж хөгжүүлэх, ажлын үр дүнг үнэлж санал санаачилгыг дэмжиж ажиллах, ажлын бүтээмж, соёлыг сайжруулах, хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгох, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэсэн аливаа эрх зүйн үндэслэлтэй шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээлэл зөвөлгөө зөвлөмжөөр хангах, хяналт тавьж ажиллах, ажлын хариуцлага сахилга батыг сахиулах, олон нийттэй харилцах, үндсэн чиг үүргээ ханган ажилласан.

“ДЦС-3” ТӨХК нь 2021 онд нийт 996 ажилтантай ажиллалаа. Үүнээс: 225 нь ИТА, 771 нь ажилтан байна. Нийт ажилтнуудын 55.0 хувь нь дээд, 12.0 хувь нь тусгай дунд, 30.0 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Нийт 996 орон тооны 241 ажилтан буюу 24.1 хувийг эмэгтэйчүүд, үлдсэн 75.9 хувийг эрэгтэйчүүд эзлэж байна.

Хүний нөөцийн бодлогын хүрээнд сул орон тооны нөхөн хангалтыг оновчтой зохион байгуулах чиглэл барьж ажилласан. Шинээр орсон ажилчдын 74.0 хувь нь мэргэжлийн дээд боловсролтой, нийт 84.0 хувь нь тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг бүрэн хангасан хүмүүс байна. Ажилтан албан хаагчдын албан тушаалын карьер хөгжлийг бодлогоор дэмжиж, мерит зарчмын дагуу ажилтнаас ИТА-д дэвшсэн 4 ажилтан байна.



Сургалтын үйл ажиллагаа

Компанийн хэмжээнд 2021 онд “Цахим сургалтыг түлхүү зохион байгуулж, цахим сургалтын үйл ажиллагааг дэмжин, сургалтын оролцоо хэрэглээг сайжруулах” зорилтыг дэвшүүлэн сургалтын 35 хувийг цахимаар зохион байгуулах зорилтоо 26.9 хувиар нэмэгдүүлж 61.9 хувьд хүргэж ажилласан.

Тайлант хугацаанд нийт 53 сургалтын үйл ажиллагаа төлөвлөснөөс 3 сургалт болон үйл ажиллагаа хийгдээгүй, нэмэлтээр 5 сургалт зохион байгуулагдаж нийт 55 сургалтанд давхардсан тоогоор 1,201 ажилтан хамрагдсан. Компанийн 2021 оны сургалт хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл 94.3 хувь байна.

Сургалтын 8 байгууллагатай гэрээ хийн хамтран ажиллаж, байгууллага дээр зохион байгуулсан гэрээт сургалтанд 421 ажилтан, гадны 14 сургалтын байгууллагад нийт 121 ажилтан тус тус сургалтанд хамрагдсан.

Компанийн мэргэжлийн шалгалтын комисст нийт 144 ажилтан шалгалт өгч 39 ажилтан албан тушаалдаа жинхэлж, 49 ажилтан мэргэжлийн зэргээ ахиулсан.

Сургалтын төлөвлөгөө, сургалт хөгжлийн үйл ажиллагааны үр дүнд 2021 онд нийт:

- 16 ажилчин мэргэжлийн үнэмлэхтэй болсон
- 394 ажилтан албан тушаалын шаардлагын дагуу эрх авсан буюу сунгасан
- 39 ажилчин албан тушаалдаа жинхлэн мэргэжилтэй ажилчин болсон
- 49 ажилчин мэргэжлийн зэргээ нэмсэн
- 1 ИТА Зөвлөх инженер болсон
- 8 инженер Мэргэшсэн инженер болон төсөвчин болсон байна.

Сургалтын үйл ажиллагааны үзүүлэлтүүд:

Хүснэгт 7. Ажилчдын сургалтанд хамрагдалтын судалгаа

| Үзүүлэлтүүд | | Хэмжих нэгж | 2019 он | 2020 он | 2021 он |
|--|------------------------------|-------------|------------|-------------|-------------|
| Нийт төлөвлөгдсөн сургалтын тоо | | тоо | 63 | 73 | 47 |
| Сургалт хөгжлийн төлөвлөгөөний биелэлт | | хувь | 93.7 | 84 | 94.3 |
| Нэг ажилтанд ногдсон сургалтын зардал | | мян.төг/хүн | 29.6 | 101.6 | 82.4 |
| Хамрагдсан ажилтны тоо | Нийт | ажилтан | 4,464 | 1,639 | 1,201 |
| | Удирдлага | | 127 | 62 | 169 |
| | ИТА | | 890 | 631 | 521 |
| | Ажилчид | | 3,447 | 946 | 511 |
| Хамрагдсан ажилтны тоо | Гадаад орны сургалтанд | ажилтан | 21 | 0 | 0 |
| | Гадны сургалтын байгууллагад | | 188 | 108 | 121 |
| | Байгууллага дээр | | 4,255 | 1,531 | 1,080 |
| Нэг ажилтанд ногдсон дундаж цаг | Нийт | цаг/хүн | 6.2 | 12.4 | 14.3 |
| | Удирдлага | | 11.9 | 14 | 16.7 |
| | ИТА | | 10.9 | 12 | 12.7 |
| | Ажилчид | | 5 | 13 | 15.2 |

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын хүнд үед компанийн ажилчдын “Аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн долоодугаар олимпиадыг “Юнител” ХХК-тай хамтран Юнителийн утсаар ТОКИ аппликейшн ашиглан цахимаар зохион байгуулсан. Олимпиадад нийт 544 ажилтан оролцож шилдгүүдээ тодруулсан.

ИТА-ын аттестатчилал

Эрчим хүчний салбарт гарч буй осол аваар саатлыг бууруулах салбарын удирдах ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор ЭХ-ний сайдын 2021 оны А/76 тоот тушаалаар Аюулгүй ажиллагааны дүрэм, техник ашиглалтын дүрмүүдийн мэдлэгийн шалгалтыг ЭХЯ-аас томилогдсон комисстой хамтран зохион байгуулсан. 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдөр ЭХЯ-ны шалгалтын комисс станц дээр ирж ажиллан эхний шалгалтыг

танхим болон цахимаар зэрэг авсан. Шалгалтанд тэнцээгүй ажилтнуудаас авсан давтан шалгалтыг цахимаар зохион байгуулсан.

Компанийн удирдлага ИТА нарын шалгалтанд оролцсон байдал:

Хүснэгт 8. ИТА нарын шалгалтанд хамрагдалтын хувь

| Үзүүлэлтүүд | | Хэмжих нэгж | 2019 он | 2020 он | 2021 он |
|--|------------------------------|-------------|------------|-------------|-------------|
| Нийт төлөвлөгдсөн сургалтын тоо | | тоо | 63 | 73 | 47 |
| Сургалт хөгжлийн төлөвлөгөөний биелэлт | | хувь | 93.7 | 84 | 94.3 |
| Нэг ажилтанд ногдсон сургалтын зардал | | мян.төг/хүн | 29.6 | 101.6 | 82.4 |
| Хамрагдсан ажилтны тоо | Нийт | ажилтан | 4,464 | 1,639 | 1,201 |
| | Удирдлага | | 127 | 62 | 169 |
| | ИТА | | 890 | 631 | 521 |
| | Ажилчид | | 3,447 | 946 | 511 |
| Хамрагдсан ажилтны тоо | Гадаад орны сургалтанд | ажилтан | 21 | 0 | 0 |
| | Гадны сургалтын байгууллагад | | 188 | 108 | 121 |
| | Байгууллага дээр | | 4,255 | 1,531 | 1,080 |
| Нэг ажилтанд ногдсон дундаж цаг | Нийт | цаг/хүн | 6.2 | 12.4 | 14.3 |
| | Удирдлага | | 11.9 | 14 | 16.7 |
| | ИТА | | 10.9 | 12 | 12.7 |
| | Ажилчид | | 5 | 13 | 15.2 |

Компанийн сургалт хөгжлийн үйл ажиллагаанд гарсан өсөлт, бууралтыг Компанийн сургалт хөгжлийн төлөвлөгөө 94.3 хувиар биелж өмнөх жилээс 10.3 хувиар, 1 ажилтанд оногдох цаг удирдлагад 14.3 цаг/хүн буюу 1.9 цаг/хүн-ээр тус тус өссөн. Сургалтанд хамрагдсан дээд болон дунд түвшний удирдлагын тоо 2.7 дахин нэмэгдсэн. Компанийн мэргэжлийн шалгалтанд давтан шалгалт өгсөн ажилтнууд өмнөх жилээс 5.8 хувь буурсан. Олон улсын хөтөлбөрт сургалтанд 3 ажилтан цахимаар хамрагдсан.

Компанийн хэмжээнд 2021 онд “Цахим сургалтыг түлхүү зохион байгуулж, цахим сургалтын үйл ажиллагааг дэмжин, сургалтын оролцоо хэрэглээг сайжруулах” зорилтыг дэвшүүлэн сургалтын 35.0 хувийг цахимаар зохион байгуулах зорилтоо 26.9 хувиар нэмэгдүүлж 61.9 хувьд хүргэж ажилласан.

Мөн ажилчдын жинхлэх, зэрэг ахих шалгалтыг ур чадварын үнэлгээний төлөвлөгөөний дагуу зохион байгуулж мэргэжлийн шалгалтын чанарыг сайжруулах зорилт дэвшүүлж зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд “Ажилчдын мэргэжлийн ур чадварын төлөвлөгөө боловсруулах заавар” боловсруулж засварын мэргэжил дээр хугацааг туршсан.

2021 онд “Компанийн цахим мэдлэгийн санг бүрдүүлэх болон ашиглуулах” судалгааны ажлыг ДХХА цехтэй хамтран хийж Компанийн цахим мэдлэгийн сангийн эхний хувилбарыг хийж гүйцэтгэсэн.

Сургалт хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл

Сургалт хөгжлийн бодлогын хүрээнд ИТА, ажилчдын ерөнхий чадамжийн сургалтыг зохион байгуулах, ИТА нарыг аттестатчилах, хувийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, байгууллагын мэдлэгийн санг бүрдүүлэх, өргөжүүлэх чиглэлд түлхүү анхаарч

ажилласан. Сургалтын төлөвлөгөөг 94.3 хувиар биелүүлж 55 сургалтанд давхардсан тоогоор 1,201 хүн хамрагдсан байна.

Өмнө жилтэй харьцуулахад:

- Нэгж ажилтанд ногдох сургалтын дундаж цаг 1.9-р нэмэгдсэн,
- Сургалтанд хамрагдсан ажилтны тоо 1.9 дахин багассан,
- ААД-ын давтан шалгалт өгсөн ажилтны тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Сургалтын 8 байгууллагатай гэрээ хийн хамтран ажиллаж, байгууллага дээр сургалт зохион байгуулсан бөгөөд гэрээт сургалтанд 421 ажилтан хамрагдсан.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг хэрэгжүүлэх зорилгоор худалдан авах ажиллагаанд оролцох мэргэшсэн ажилтан бэлтгэх, эрхийн хугацаа дуусч байгаа ажилтны эрхийг сунгах Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны АЗ сургалтыг сүүлийн 4 жилд МУИС, Бизнесийн сургуультай хамтран зохион байгуулж байна. 2022 оны эхний хагас жилд эрхийн хугацаа нь дуусах болон шинээр эрх авах шаардлагатай 38 ажилтны сургалтыг Microsoft Teams meeting програмаар 2021 оны 11-р сард 2 ангиар тус бүр 3 өдрийн 7 цагаар цахимаар зохион байгуулж Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр шалгалтыг өгүүлсэн.

“Цахим хичээл боловсруулах арга зүй” сэдэвт сургалт:

Цар тахлын үед сургалтуудыг зайнаас болон цахимаар явуулах шаардлага үүссэн тул байгууллага дээр зохион байгуулагддаг тогтмол сургалтуудад хичээл заадаг инженерүүдэд цахим хичээл боловсруулах, заах, цахим сургалтын анхан шатны мэдлэг, ур чадвар олгох сургалтыг ЭХХТ, СҮТ-ийн багш Х.Эрдэмбилэгтэй хамтран сургалтын танхимд зохион байгуулсан.

“Цахим хичээл боловсруулах арга зүй” сэдэвт 8 цагийн сургалтыг 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр “ДЦС-3” ТӨХК-ийн Соёлын төвийн Сургалтын танхимд зохион байгуулж сургалтанд нийт 12 ИТА хамрагдсан.



Хөдөлмөрийн шинэчилсэн хуулийн сургалт:

Компанийн удирдлага, алба, хэлтсийн дарга нар, Захиргаа хүний нөөцийн албаны мэргэжилтэн нийт 16 ажилтанд Хөдөлмөрийн шинэчилсэн хуулийн мэдлэг олгох “Хөдөлмөрийн тухай хуулинд ажил олгогчтой холбоотой орсон шинэ хуулийн зохицуулалт,

хэрэглээ” сэдэвт 3 цагийн сургалтыг 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Найрамдал танхимд зохион байгуулсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг сэргээх сургалт



Техник хяналтын хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан инженерүүдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ойлголт, бүтэц, баримт бичиг, ажилбар, асуудал, шийдлүүдийн талаарх онолын болон практик мэдлэг олгох, мэдлэг сэргээх 8 цагийн сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 2-3-ны өдрүүдэд компанийн Сургалтын танхимд зохион байгуулсан.

Ажилтныг хөгжүүлэх үйл ажиллагаа

Аюулгүй ажиллагааны дүрмийн мэдлэгийн YII олимпиад:



Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын хүнд үед компанийн ажилчдын “Аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн Долоодугаар олимпиадыг Юнител ХХК-тай хамтран Юнителийн утсаар **ТОКИ** аппликейшн ашиглан цахимаар зохион байгуулсан.

Эрчим хүчний ирээдүйн удирдагчид хөтөлбөр

Эрчим хүчний яам Дэлхийн эрчим хүчний Зөвлөлийн Монгол дахь хороо хамтран гадаад улсад магистр хамгаалсан анхан шатны байгуулагуудад ажиллаж байгаа ажилтнуудаас сонголт хийснээс, ЭХ-ний салбарын манлайлагч нарыг бэлтгэх менторын хөтөлбөрт БНХАУ-д магистр төгссөн ЦЦ-н монтёр М.Сарангэрэл, ОХУ-д улсад магистр төгссөн ТБХ-н судалгааны инженер Л.Ирээдүйлхүмбэ нар хамрагдсан. Хөтөлбөрт хамрагдсан 2 ажилтан хөтөлбөрийн явц, үр дүнгийн талаар дотоод сүлжээний программаар ажилтнуудыг мэдээллээр хангаж ажилласан.

10. ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ, ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ АЖИЛ



2018 онд батлагдсан “ДЦС-3” ТӨХК-ийн 2032 он хүртэл баримтлах техникийн бодлогын баримт бичигт тусгагдсаны дагуу 2021 онд төлөвлөгдсөн ажлуудыг хийсэн.

Техникийн бодлогын бичиг баримтын 2032 он хүртэлх нийт ажлын гүйцэтгэл 49.2 хувьтай байна.

| Хийгдсэн ажил | Техникийн бодлогын хүрээнд хийж хэрэгжүүлсэн техник технологийн шинэчлэл | Гарсан үр дүн |
|---|---|--|
|  | <p>Зуух №1-н хоригийн хэлхээг ПЛК-д, утаа сорогч, үрлэн тээрмийн хамгаалалтыг микропроцессорын (N-IDN-MA) хамгаалалтад шилжүүлсэн.</p> | <p>Хориг хамгаалалтууд сайжирснаар хамгаалалтын хурд сайжирч тоноглолыг гэмтлээс сэргийлнэ. Үндсэн тоноглолын төлөвлөгөөт бус зогсолт буурна.</p> |
|  | <p>Станцын II шатны шинэчлэл 2X250 МВт шинэ станц барих төслийн ажил дээр ОХУ-ын ИНТЕР РАО компанитай санамж бичиг байгуулсан. Ажлын даалгавар болосвсруулж гүйцэтгэгч талд өгсөн. ТҮШ, ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж байна.</p> | <p>Шинэчлэлийн төсөл хэрэгжсэнээр УБ хотын дулаан хангамжийн өсөн нэмэгдэж буй хэрэглээг хаах боломж бүрдэнэ. дулаанаар 31.0 мянга, цахилгаанаар 60.0 мянга орчим айл өрхийг ЭХ-ээр хангах боломж бүрдэнэ.</p> |
|  | <p>Нүүрс хадгалах ил агуулахыг битүү агуулах болгон өөрчлөх урьдчилсан ТЭЗҮ боловсруулсан. Агуулах барих ажилд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүн дээр 3 хувилбарыг авч үзсэн.</p> | <p>Төсөл хэрэгжсэнээр нүүрсний хорогдол буурч нүүрсээр бохирдох экологийн сөрөг нөлөөллийг бууруулна.</p> |
|  | <p>Доорх ажлуудыг 2022 хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> ➢ ӨДС-н 25 МВт-н генераторын өдөөлтийн системийг статик өдөөлтийн системээр шинэчлэх, ➢ Үнсээр дүүрсэн хуучин үнсэн сангийн үнсийг суллах, даланг дахин ашиглах | <p>Станцын тасралтгүй, найдвартай ажиллагаа хангагдана.</p> |

**“ДЦС-3” ТӨХК-ИЙН 2022 ОН ХҮРТЭЛ БАРИМТЛАХ ТЕХНИКИЙН БОДЛОГЫН
БАРИМТ БИЧГИЙН БИЕЛЭЛТ**

Хүснэгт 9. ДЦС-3 ТӨХК-ийн урт хугацааны техникийн бодлогын бичиг баримтын биелэлт

| д-д | Хэрэгжүүлэх ажлууд | Төлөвлөсөн хугацаа | Гүйцэтгэл /хувиар/ | Тайлбар |
|--|---|--------------------|--------------------|--|
| Үйлдвэрлэлийн ашигт ажиллагааг дээшлүүлэх, найдвартай ажиллагааг хангах чиглэлийн хүрээнд | | | | |
| 1 | Насос станц, тунгаах усны насосны 6/0.4 кВ-н хуваарилах байгууламж, шулуутгагч байгууламжийг шинэчлэх, аянгын хэт хүчдэлээс хамгаалах төхөөрөмжөөр хангах | 2018-2019 он | 75.0 | - 2019 онд хуваарилах байгууламжийг шинэчлэх ажил хийгдэж байна. - 2020 онд ТУН сольсон |
| 2 | DCS /Distributed Control System/-Тоног төхөөрөмжийг бүрэн автомат хяналт удирдлагын системд шилжүүлэх | 2018-2021 он | 100.0 | - ӨДС-ыг хяналт удирдлагыг бүрэн автомат DCS удирдлагатай болгох судалгаа тооцоог хийж танилцуулсан. - ӨДС-ын дулаанжуулалтын туслах тоноглолуудын хяналтын системийг компьютерийн хяналтын системд оруулсан. |
| 3 | Өндөр даралтын хэсгийн зуухны утаа сорогч, үлээх салхилуур болон зуух тэжээх насос /ПЭН/-д давтамж хувиргагч суурилуулах. | 2018-2021 он | 100.0 | - ӨДС-ын ПЭН-7-д хувьсах зарцуулалтын насос суурилуулсан. - 2019 онд Зуух №9-ийн утаа сорогч үлээх салхилуурт давтамж хувиргагч суурилуулах ажил хийгдсэн. |
| 4 | Хуучин РХ-ын микропроцессорын хамгаалалтаар солих, шинэчлэх | 2018-2021 он | 40.0 | - Тэжээлийн усны насосуудын АВР шинэчилсэн. - 2021 онд зуух №1, 7, 13 шинэчилсэн. |
| 5 | ӨДС-н 25 мВт-н генераторын өдөөлтийн системийг статик өдөөлтийн системээр шинэчлэх | 2018-2021 он | 25.0 | - Турбингенератор №5-д статик өдөөлтийн систем суурилуулсан. - 2022 онд ТГ-7 дээр солигдоно. |
| 6 | Галлагааны РОУ-гийн коллектор шинэчлэн солих | 2018-2021 он | 100.0 | - 2019 онд бүрэн хийгдэж дууссан. |
| 7 | Хурц уурын коллекторын катушкууд, тройникуудыг шинэчлэн солих | 2018-2021 он | 100.0 | - 2019 онд шинэчлэх ажлыг бүрэн хийсэн. |
| 8 | Зуух №9-н хурц уур, тэжээлийн усны коллекторуудыг шинэчлэн солих | 2018-2021 он | 100.0 | - 2018 онд зуух №9-ийн регуляторуудыг Аума фирмийн актуатороор шинэчлэх ажлыг хийсэн. |
| 9 | Кабелийн канал трасс, кробка, тавиуруудыг шинэчлэх | 2018-2021 он | 25.0 | - ЭУН-ын кабелийн сувгийн тавиурууд сольсон. - ТГ-5, 6 эргэлтийн усны кробка таг шинэчилсэн |
| 10 | ПТ-25-90/10М турбинуудын өндөр, дунд даралтын цилиндр, /ЧВД, ЧСД/ роторыг солих | 2018-2027 он | 15.0 | - Судалгаа хийгдэж байгаа. - Үйлдвэрлэгчтэй холбогдож үнийн санал гаргуулан авсан. |
| 11 | JOS /Joint Operation System/ - Өндөр даралтын | 2022-2027 он | 20.0 | - Өндөр даралтын станцын тоног төхөөрөмжийг нэгдсэн хяналт, |

| | | | | |
|---|---|--------------|-------|--|
| | станцын тоног төхөөрөмжийг нэгдсэн хяналт, удирдлагын системд шилжүүлэх | | | удирдлагын системд шилжүүлэх судалгаа тооцоог хийж Эрчим хүчний яамны ШУТЗ-д танилцуулсан. |
| 12 | Хурц уурын шугам шинэчлэн солих | 2022-2032 он | | |
| 13 | Хөргөх цамхагийн дулааны алдагдлыг ашиглан дулааны насос суурилуулан хэрэглэгчдийг дулаанаар хангах. | 2028-2032 он | 20.0 | - Урьдчилсан судалгаа тооцоог хийсэн. |
| Тоног төхөөрөмжийг шинэчлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх чиглэлийн хүрээнд | | | | |
| 14 | Техникийн ус хангамжийн гол шугамыг солих | 2018-2019 он | 100.0 | - 2016 оноос эхлэн үе шаттайгаар шинэчлэх ажлыг эхлүүлж 2018 онд бүрэн хийж дуусгасан. |
| 15 | Станцын II шатны шинэчлэл. /250 МВт шинэ станц барих/ | 2018-2021 он | 20.0 | - ОХУ-ын Интер РАО экспорт компанитай хамтран ТЭЗҮ-ийг боловсруулсан. - 2021 онд Санамж бичиг байгуулсан. Ажлын даалгавар болосвруулж гүйцэтгэгч талд өгсөн ТЭЗҮ хийлгэж байна. |
| 16 | ПТ-25-90/10М турбинд конденсатарын бөмбөлгөн цэвэрлэгээний систем суурилуулах | 2018-2021 он | 20.0 | - Техник технологийн судалгаа тооцоог хийж танилцуулсан. |
| 17 | ПТ-25-90/10М турбинуудын конденсатор, эргэлтийн усны системийг шинэчлэх, хөргөх усан санг шинэчлэн шинээр хөргөх цамхаг барих | 2022-2027 он | 20.0 | - “ДЦС-3” ТӨХК-ийн өндөр даралтын станцын суурилагдсан хүчин чадлыг 75 МВт-аар нэмэгдүүлэх төслийн хүрээнд техникийн шийдлийг боловсруулж, судалгаа тооцоог хийсэн. |
| 18 | Өндөр даралтын станцын ПТ-25-90/10М маягийн турбогенератор №5 –ыг 50MW турбинээр хүчин чадлыг нэмэгдүүлэн шинэчлэх | 2022-2027 он | 20.0 | - “ДЦС-3” ТӨХК-ийн өндөр даралтын станцын суурилагдсан хүчин чадлыг 75 МВт-аар нэмэгдүүлэх төслийн ТЭЗҮ боловсруулж, судалгаа тооцоог хийсэн. - Ажлын даалгавар боловсруулсан - Санамж бичиг байгуулсан. |
| 19 | Өндөр даралтын станцын БКЗ-220-100 зуухнуудыг нам температурын буцалгагч үет шаталтын технологид шилжүүлэх | 2018-2032 он | 40.0 | ➢ 2019 онд урьдчилсан судалгаа тооцоог хийж, Эрчим хүчний яамны ШУТЗ-д танилцуулсан. ➢ 2020 онд зураг төсвийг хийж экспертизээр батлуулсан. |
| 20 | Өндөр даралтын станцын ПТ-25-90/10М маягийн турбогенераторуудыг 50MW турбинээр хүчин чадлыг нэмэгдүүлэн шинэчлэх | 2028-2032 он | 20.0 | ➢ “ДЦС-3” ТӨХК-ийн өндөр даралтын станцын суурилагдсан хүчин чадлыг 75 МВт-аар нэмэгдүүлэх төслийн ТЭЗҮ боловсруулж, судалгаа тооцоог хийсэн. |
| 21 | Энерги хадгалах систем, шинэ технологи нэвтрүүлэх | 2028-2032 он | 20.0 | ➢ Урьдчилсан судалгаа тооцоог хийсэн. |
| 22 | Шинэ үнсэн сан барих | 2018-2020 он | 100.0 | ➢ 2018 онд зураг төсөв хийлгэсэн. ➢ 2019 онд шинэ үнсэн сан барих ажлыг эхлүүлсэн. ➢ 2020 онд барьж дууссан. |

| | | | | |
|------------------|---|--------------|-------|---|
| 23 | ОРУ-35, 110 кВ-н тосон таслуурыг элегаз таслуураар шинэчлэх, изляторууд, хуурай салгууруудыг тосон таслууруудтай нь хамт шинэчлэх | 2018-2021 он | 100.0 | <ul style="list-style-type: none"> ➤ 2018 онд ТГ №6-ийн элгаз таслуурыг сольсон. ➤ 2019 онд ОРУ-ын 110 кВ-ын хуурайн салгуур солих ажил хийгдэж байна. ➤ 2020 онд ОРУ-110 кВ-ын ТГ-5-д 9 ш хуурай салгуур сольсон. |
| 24 | Техникийн усны хэрэглээг бууруулах, саарал ус ашиглах технологи нэвтрүүлэх | 2018-2021 он | 25.0 | <ul style="list-style-type: none"> ➤ АНУ-ын мянганы сорилтын корпорацитай хамтран судалгаа хийж, техникийн шийдлийг боловсруулсан. ➤ ТЭЗҮ зураг төсөл хийгдэж байна. |
| 25 | Зуухнаас ялгарах утааны хийн үнсийг ялгах, үнсийг хуурайгаар зайлуулах технологи нэвтрүүлэх | 2022-2027 он | 20.0 | <ul style="list-style-type: none"> ➤ 2017 онд судалгааг хийсэн. ➤ Герман улсын Штайнмюлер компанийн тоног төхөөрөмжийн судалгааг хийж байна. |
| 26 | Үнсээр дүүрсэн хуучин үнсэн сангийн үнсийг суллах, даланг дахин ашиглах | 2022-2027 он | 25.0 | <ul style="list-style-type: none"> ➤ Судалгааг хийсэн. ➤ Зураг, төсөв хийлгэхээр 2022 оны төлөвлөгөөнд тусгасан. |
| 27 | Нүүрс хадгалах ил агуулахыг битүү агуулах болгон өөрчлөх | 2028-3032 он | 30.0 | <ul style="list-style-type: none"> ➤ 2018 онд судалгаа хийж, техникийн шийдлийг боловсруулсан. ➤ Ажлын хэсэг байгуулан урьдчилсан ТЭЗҮ хийж 3 хувилбараар судалсан. |
| ГҮЙЦЭТГЭЛ | | | 49.2 | |

2x50 МВТ, 2x125 МВТ ТӨСӨЛ


Өндөр даралтын хэсгийн хүчин чадлыг 75 МВт-аар нэмэгдүүлэх, Станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх төслийн хүрээнд ажлын даалгаврыг боловсруулж холбогдох цехүүдээр хэлэлцүүлэн саналыг нь авч ТЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж Интер РАО компанид өгч ТҮШ, ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж байна. Мөн 2x150МВт төслийн ажлын даалгаварыг боловсруулан батлуулсан

Төслийн хүрээнд ОХУ-ын Интер РАО экспорт компанийн мэргэжилтнүүдтэй 2021 оны 09-р сарын 20-30 өдөр уулзалтыг зохион байгуулж төслийн ажлын даалгаврын хүрээнд ТЭЗҮ-ийн техникийн болон хэрэгжүүлэх хугацааг тохирч протокол хөтлөн санамж бичиг байгуулан замын зураглал төлөвлөгөө гарган ажиллаж байна. ТЭЗҮ боловсруулахад шаардлагатай анхдагч мэдээллүүдийг гарган өгч хамтран ажиллаж байна.




- Цахилгаан болон дулаан дамжуулах сүлжээний өргөтгөлтэй холбоотой ажлуудыг ЭХЯ, ДҮТ, ЦДҮС, ДШС-тэй хамтран боловсруулж гарган ажлын даалгаварт тусгаж гүйцэтгэгч компанид өгсөн.

1. Цахилгаан дамжуулах, түгээх шугамын нэвтрүүлэх чадварыг нарийвчлан тооцох, өргөтгөх шинэчлэх техникийн шийдлийг боловсруулсан.



Цахилгаан дамжуулах 103/104, 105/106, 111/112-р ЦДАШ-н дамжуулах чадварыг 2 дахин нэмэгдүүлэх ИХБ-3,220 КВ-оор өргөтгөх ажил хийгдэнэ.

Дулаан дамжуулах шугамын өргөтгөл




Хотын сүлжээний 5А магистралийн 2хФ820мм-ийн 2.8 хос км шугамыг 2х1,020 мм болгон өргөтгөх /Дэлхийн банкны санхүүжилтээр 2022 онд барилга угсралтын ажил хийгдэж байна/

10 вгд магистралийн 2хФ820 мм-ийн 4.1 хос км шугамыг 2хФ1,020 мм болгож өргөтгөх. Насосны станц №3-ын өгөх, буцах усны насосны хүчин чадлыг 5,500 тн/ц болгож нэмэгдүүлэхээр ажлын даалгаварт тусгасан.

11. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ТАЛААР

2021 онд эрчим хүчний хэмнэлтийг бий болгож дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчийг бууруулах чиглэлээр дараах техник зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч ажилласан. Үүнд:

- ДДТурбин цех ТГ №1-н улайсах гэрлийг 31ш LED гэрлээр, 1.2 ата деэраторын арын эгнээг 13ш LED гэрэлтүүлэгчээр шинэчилсэн. Хими цех давсны аж ахуйн 500 Вт улайсах төрлийн гэрлийг 8ш 200 Вт-ын, заалны гэрэлтүүлгүүдийг LED гэрэлтүүлэгчээр шинэчлэн тайлан онд 17.3 мян.кВт.ц ЦЭХ хэмнэсэн.
- Дотоод хэрэгцээний дулааны хэрэглээг бууруулах зорилгоор үндсэн цехүүдэд дулаацуулгыг хааж 1 насос бэлтгэлд зогсоох, эргэлтийн усны нососын давтамж хувиргуураар ачаалал бууруулж ДХЦЭХ-ийг өмнөх оноос 154 мян.кВт.ц-аар хэмнэлт гаргаж ажилласан.
- Тоосон системийн эсэргүүцэл, сийрэгжилтийн хэмжүүрүүдийг тоон хэмжүүрээр сольж шинэчилсэн. Хэмжүүрийн ажиллагаа найдвартай болж, дотоод хэрэглээний зарцуулалт буурч датагаа архивладаг болсон.
- ӨДС-ын зуух №9 утаа сорогч, үлээх салхилуурын инвертерийн ажиллагааг сайжруулснаар 1,011.4 мян.кВт.ц ДХЦЭХ хэмнэсэн.
- ӨДС-ын зуух №11 үлээх салхилуур-Б-ийн инвертерийн ажиллагааг нэмэгдүүлснээр 241.1 мян.кВт.ц ДХЦЭХ нь хэмнэсэн байна.
- Тунгаах сангийн саарал усны хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр 19 ажлын төлөвлөгөө гарган ажилласан. ДДЗ, ӨДЗ, Засварын цехүүдтэй дараах ажлуудыг хэрэгжүүлсэн.
- Саарал усны схем татаж бүх зуухнуудад бүрэн ашиглаж эхэлсэн.



- ДДЗ цехийн барбатёрын хөргөлтийг саарал усаар хөргөх ажлыг хийсэн.

- ТДЦ-ийн тоос намжаах төхөөрөмж рүү саарал ус ашиглах схемийн өөрчлөлтүүд хийж ашигласан. Түлшний аспираци, угаалга цэвэрлэгээнд тунгаах сангийн саарал усыг дахин ашиглаж 28.8 мян.тн техникийн ус хэмнээд байна.

- ДДЗ, ӨДЗ цехүүдэд угаалга цэвэрлэгээнд 100 хувь, сорьцийн хөргөлтөнд саарал усыг ашиглаж техникийн усны хэрэглээг бууруулан

ажилласан.

- 2021 онд техникийн усыг төлөвлөгөөнөөс 793 мян.тн-оор хэмнэсэн ба энэ нь мөнгөн дүнгээр 56.1 сая төгрөг хэмнэсэн байна. 2020 онд техникийн усны дундаж зарцуулалт G=988 т/ц байсан бол 2021 онд дундаж зарцуулалт G=680 т/ц болж 308т/ц-аар буурсан.

Гэрэлтүүлгийн ДХЦЭХ-ийг ойролцоогоор хоногт 144 кВт.ц, жилд 52,560 кВт.ц цахилгаан эрчим хүч буюу жилдээ 5.3 сая төгрөг бууруулах боломж бүрдсэн.

2021 онд шинэчилсэн гэрэлтүүлэгчийн чадлын зөрүүгээр (сүүлийн 4 сарын хэрэглээ) 17.3 мян.кВт.ц ЦЭХ буюу 1.8 сая төгрөг хэмнэсэн.

Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын үр дүнд гарсан үр ашиг нь жилийн дүнгээр 171.3 мян.кВт.ц цахилгаан эрчим хүчийг хэмнэсэн.

Алдагдлыг бууруулж түлш, уур ус, эрчим хүчний хэмнэлт гаргах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх талаар ажлуудыг зохион байгуулж хийснээр станцын хэмжээнд 294.4 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.

12. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКОЛОГИ, БАЙГАЛЬ ОРЧИН

- Тус компани нь байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын яамаар батлуулсан гүйцэтгэлийг Нийслэлийн байгаль орчны газарт хуулийн хугацаанд нь хүргүүлж ажилласан.
- БОХМТөлөвлөгөөнд 5 үндсэн бүлэгт 39 ажил төлөвлөн 100.0 хувь хийж гүйцэтгэсэн.
- Байгаль орчны талаар баримтлах бодлогын баримт бичгийн тухайн онд тусгасан ажлуудыг холбогдох алба, хэлтэс, цех, хэсгүүдтэй хамтарч 2021 онд хийгдэх 8 ажил хийхээр төлөвлөж үүнээс 7 ажил хийгдсэн.
- Нүүрсний зарцуулалт- Станц нь 2021 онд 1,412,477.8 тн Багануурын уурхайн нүүрс үйлдвэрлэлд ашигласан нь өмнөх оноос 79,832 тн-оор бага байна. Нүүрсний үнслэг 9.8 хувьтай гарсан ба үнс хадгалах санд 115,000 тн үнс хаясан.
- Мазут, солярка зарцуулалт: 2021 онд ДДСтанц 133 тн мазут, 8,644 л солярка, ӨДСтанц 711 тн нийт станцын дүнгээр 844 тн мазут түлсэн.
- Техникийн усны зарцуулалт: 2021 онд техникийн усны зарцуулалт 6,387.3 мян тн гарч төлөвлөгөөнөөс 562.5 мян.тн хэмнэлттэй ажилласан. Насос станцын гүний усны нөөцийн статик, динамик төвшинд ойрын жилүүдэд судалгаа хийгдээгүй байсан. Хамгийн сүүлд 2007 онд тооцож үзэхэд эх үүсвэрийг цаашид 14 жил ашиглаад дахин хэмжилт судалгаа хийх зөвлөмжийг үндэслэн 2021 оны 06 дугаар сард гүний худгуудад хэмжилт, судалгааны ажил хийж түвшинг дахин тогтоосон. Судалгааны ажлын үр дүнд хоногт олборлох усны хэмжээ, нөөц 2007 оны үзүүлэлтээс 6,500 м3/х-оор буурч 31,000 м3/хоног болсон байна. Мөн дээрх судалгааны ажлыг үндэслэн өөрийн эзэмшил 18 гүний худгуудыг Улсын нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулалт хийн паспортжуулсан.
- Агаар бохирдуулах хорт бодисын хяналт: Станцын яндангаар хаягдаж байгаа хорт бодисын хэмжээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа MNS 5919:2008 стандартаас хэтрээгүй боловч ӨДСтанц болон ДДСтанцын зуух тус бүрт хяналтын шинэ төхөөрөмж хэрэгтэй байна. Энэ онд станцын хувьд үнс хадгалах сан, тунгаах сангийн түвшин тохируулах боломжгүй болж Туул гол руу үнстэй ус хаясан, салхи ихтэй өдрүүдэд хуучин сангаас үнс дэгдсэн зэрэг зөрчлүүд гарсан. Дээрх зөрчлүүдийг арилгах ажлын хүрээнд Туул голын 2.4 км үргэлжилсэн 10 га талбайг цэвэрлэх, нөхөн сэргээх ажлыг богино хугацаанд зохион байгуулан хийж хариуцагч байгууллагад хүлээлгэн өгсөн.

13. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР



Станцын хэмжээнд аваар, сааталгүй, галын ноцтой зөрчилгүй, хэмжих хэрэгслийн графикт баталгаажуулалтыг хугацаанд нь хийж, станцын дотоод циклийн химийн уур-усны горим, түлш, тосны чанарт хяналт тавьж зөрчилгүй ажилласан хэдий ч үйлдвэрлэлийн осол 2-той ажиллалаа.

Сүүлийн 3 жилийн хугацаанд технологийн зөрчлийн тоо жил дараалан бууж байгаа бөгөөд 2021 онд нийт технологийн зөрчлийн тоог өмнөх оноос 24.2 хувиар бууруулж ажиллалаа.

Технологийн зөрчил, гал түймэр, үйлдвэрлэлийн ослын харьцуулсан судалгаа

| Д/д | Үзүүлэлт | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | 2021 он |
|-----|------------|---------|---------|---------|---------|---------|---------|
| 1 | Аваар | - | - | - | - | - | - |
| 2 | Саатал-I | - | 1 | - | - | - | - |
| 3 | Саатал-II | 1 | 1 | - | - | - | - |
| 4 | Гэмтэл | 63 | 45 | 41 | 35 | 33 | 25 |
| 5 | Гал түймэр | - | - | - | - | - | - |
| 6 | Осол | 1 | - | - | 3 | - | 2 |

2021 онд гарсан технологийн зөрчил болон үйлдвэрлэлийн ослын нэгдсэн дүн

| Д/д | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|-----|---|-------------|------|------|------|------|------|------|
| 1 | Аваар | тоо | - | - | - | - | - | - |
| | Үүнээс Хүний буруугаар Техникийн шалтгаан | | | | | | | |
| 2 | Саатал-1 | тоо | - | 1 | - | - | - | - |
| | Үүнээс Хүний буруугаар Техникийн шалтгаан | | | 1 | | | | |
| 3 | Саатал-2 | тоо | 1 | 1 | - | - | - | - |
| | Үүнээс Хүний буруугаар Техникийн шалтгаан | | 1 | 1 | | | | |
| 4 | Гэмтэл | тоо | 63 | 45 | 41 | 35 | 33 | 25 |
| | Үүнээс Хүний буруугаар | | 9 | 5 | 6 | 3 | 1 | 4 |
| | Техникийн шалтгаан | | 49 | 35 | 31 | 28 | 26 | 15 |
| | Гадны байгууллага | | 5 | 5 | 4 | 1 | 6 | 6 |
| 5 | Үйлдвэрлэлийн осол | тоо | 1 | - | - | 3 | - | 2 |
| | Үүнээс Нас барсан | | | | | 1 | | |
| | Хүнд | | | | | 2 | | 2 |
| | Хөнгөн | | 1 | | | | | |
| 6 | Гал | тоо | - | 2 | 2 | 2 | 1 | - |
| | Үүнээс Гал түймэр Галын зөрчил | | - | - | - | - | - | |
| 7 | Ариун цэвэр | Дүн | 3.96 | 3.97 | 3.95 | 3.93 | 3.92 | 3.98 |
| 8 | Тоосжилт | Мг/м | 16.8 | 17.7 | 17.5 | 21.0 | 19.1 | 19.4 |

2021 онд компанийн хэмжээнд гадны байгууллагаас шалтгаалсан аваар 1 удаа гарсан ба нэг ба хоёрдугаар зэргийн саатал гараагүй, гэмтэл 19 удаа, гадны байгууллагаас хамаарсан гэмтэл 6 удаа, нийт судлан бүртгэгдсэн гэмтэл 25 удаа гарсан. Гэмтлийн улмаас 606.01 мян.кВт.ц диспетчерийн графикийн зөрчил авсан.

Техник хяналтын талаар

МХЕГ-ын бүртгэлтэй нийт 18 тоноглолд батлагдсан графикийн дагуу техникийн магадлал хийлгэх графиктай байснаас 15 тоноглолд техникийн магадлал хийлгэж, ашиглах зөвшөөрөл авсан ба 3 тоноглолын акт формуляр, протоколын бүрдүүлэлт хийгдсэн.

Техникийн аюулгүй байдлыг хангуулах III шатны үзлэгийг “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм”-ийн хүрээнд жилд 2 удаа хийж, үзлэгээр илэрсэн зөрчлийг цаг хугацаа, шийдвэрлэх хүрээнээс нь хамааруулан цех, хэсэгт үзлэгийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөө гарган зөрчлийг арилгуулж ажиллав.

2021-2022 оны цехүүдийн өвлийн бэлтгэл хангасан байдалд үзлэг хийх комиссын дагуу даралтат сав, шугам хоолойн баталгаажилт, эрх сунгасан байдал, ТАД, ААД-ийн шалгалтын график мөрдөлт гэсэн чиглэлээр шалгалт явуулав.

Нийт 201 ИТА нараас ээлжит, шинээр жинхэлж байгаа болон зэрэг ахих 47 ажилтнаас ТАД-ийн мэдлэгийн ээлжит шалгалтыг авав.

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах талаар

“ДЦС-3” ТӨХК-д суурилагдсан тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар, үйлчилгээ хийх үйл ажиллагаатай уялдуулан ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах, нарядын системийн тусгай үүрэг хүлээгчид, оосорлогч дохиочин, ӨЗМ-ын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааг хариуцагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, ашиглалт засварын ажлын үеийн аюулгүй ажиллагааг хангуулах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахаас урьдчилан сэргийлэх, наряд (ам шийдвэр)-аар хийгдэж байгаа ажлын аюулгүй байдалд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах, ажлын байруудад өгөгдөж байгаа өдөр тутмын зааварчилгааны чанар, ажилтнуудын авч байгаа мэдээллийг сайжруулах талаар цех, нэгжээс хийж байгаа ажилд хяналт тавих, ажилтнуудын нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, тусгай хувцсыг ажлын байранд хэрэглүүлж хэвшүүлэх, ажлын байранд байгаа аливаа эрсдлийг олж илрүүлэх, хувь хүний эрсдлийн үнэлгээ “ТАКЕ-5” системийн хэрэгжилтэнд хяналт тавих, станцын нийт ажилтнууд болон гэрээгээр ажил гүйцэтгэж буй гадны байгууллагын ажилтнуудын ААД, ТАД, ГАУСД-ийн мөрдөлтөнд хяналт тавих ажилд үндсэн ажлаа чиглүүлж ажиллаа.

2021 оныг “Тоног төхөөрөмжийн цоож, пайзны системийг чанд мөрдөж ажиллах жил” болгох зорилт дэвшүүлж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллав. Зорилтын хүрээнд цехүүдэд “Цоож, пайзны систем”-ийн талаар цахим сургалт явуулсан. 2021 оны 06-р сард “Цахилгаан ба дулааны тоног төхөөрөмжинд цоож, пайз тавих авах журам”-ын талаар гарын авлага ном 780 ширхэгийг хэвлүүлж, цех, нэгжүүдэд хуваарилан олгосон. Мөн засвар хийгдэхээр зогссон тоноглолд “Цоож, пайз” тавьж, авч байгаа талаар бодит байдал дээр



сургалтын видео хэлбэрээр зураг авалт хийж, сургалтанд ашиглахад бэлдэж, дотоод сүлжээгээр үзүүлж, сурталчилах ажил хийгдэв.

Компанийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдлыг жигд хангуулах үүднээс нарядын системийн тусгай үүрэг хүлээгсэдийг Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/02 тоот тушаалаар томилж ажиллуулан хариуцлагын тогтолцоог бүрдүүлж ажиллав.

Нарядаар гүйцэтгэх ажлын жагсаалт, ам шийдвэрээр гүйцэтгэх ажлын жагсаалтыг нэгтгэн гаргаж, Гүйцэтгэх захирлаар батлуулан мөрдөж ажиллан гүйцэтгэлд хяналт тавьж ажиллалаа.

Цехүүдийн ХАБ-ыг хангуулах I, II шатны үзлэгийн чанар гүйцэтгэл, журнал хөтлөлт, зөрчил устгасан байдлыг сард 2 удаа шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулж ажиллав. Мөн ХАБ-ыг хангуулах III шатны үзлэгийг улирал бүр батлагдсан хөтөлбөр, сэдвийн дагуу 4 удаа зохион байгуулж, үзлэгийн дүнгийн хурлын мөрөөр хийгдэх ажлын төлөвлөгөө гарган гүйцэтгэлд хяналт тавьж ажиллав.

2021 онд сар бүр хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах талаар дараах зорилтуудыг дэвшүүлж, төлөвлөгөө гарган гүйцэтгэлд хяналт тавьж ажиллав.

2021 онд хувь хүний эрсдлийн үнэлгээ буюу ТАКЕ-5 хуудас 20,001 ширхэг бичигдэж, 2,650 эрсдлийг мэдээлж, 2,663 аюулыг илрүүлэн устгаж ажиллав. Эрсдлийн үнэлгээ хийх нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллав. Эрсдлийн үнэлгээг хэрхэн хийсэн, эрсдлийг бууруулах ажлын төлөвлөгөөний биелэлтэнд тогтмол хяналт тавьж ажиллав. 2021 онд нийт 64 ажлын байранд эрсдлийн үнэлгээ хийгдсэн.

2021 онд давхардсан тоогоор ээлжит зааварчилгаанд 9,904, ээлжит бус зааварчилгаанд 10,991, өдөр тутмын зааварчилгаанд 89,657 ажилтан хамрагдсан. 2021 онд аюулгүй ажиллагааны сургалтуудыг нэгж, хэсгүүдэд төлөвлөн хийсэн. Ковидын халдвараас шалтгаалан сургалтуудын 80.0 хувь орчим нь онлайн хэлбэрээр хийгдсэн. Шинээр ажилд орсон иргэний сургалтыг танхимаар сургалтын хэсэгтэй хамтран ТХХ-ийн ХАБ хяналтын инженер болон цехийн ХАБ инженерүүд хийж байна.

Галын аюулгүй байдлыг хангуулах талаар

Гэрээт галын хэсэг болон станцын галын тоног төхөөрөмжийн засварын бригадтай хамтарч, галын тоноглолуудын бэлэн байдал, усан хангамж, хөөсөөр гал унтраах систем, утаа мэдээлэх систем, галын нарядын мөрдөлт, шатах тослох материал, түүний хадгалалт хамгаалалт, ашиглалт, ажлын байрны тоос тос, мазутын болон цахилгааны кабель сувгийн цэвэрлэгээ, гал унтраах багаж хэрэгслэлийн хангалт түүний ашиглалт, хадгалалт хамгаалалт, галын аюулаас сэрэмжлүүлэх санамж, тэмдэг, плакатуудын ашиглалт зэрэг нэн түрүүнд галын аюулгүй байдлыг хангах анхан шатны шаардлагатай 4 сэдвээр батлагдсан графикайн дагуу сар бүр хяналтын үзлэг хийж, гарсан зөрчлийг холбогдох цех, хэсгийн удирдлагуудад хугацаатай шаардлага өгч, зөрчлийг арилгуулж ажиллав.

Гал унтраах тактикийн сургуулийг Улсын Онцгой комисс, эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу



оролцогчдын халдвар хамгааллын дэглэмийг бариулан “ДЦС-3” ТӨХК-ийн Дунд даралтын зуухан цехийн 31, Гал түймэртэй тэмцэх гэрээт хэсгийн 9, ГТУА-14 дүгээр ангийн 13, аврах 105-р ангийн 7, Дотоодын цэргийн 05 дугаар ангийн хамгаалалтын 3 дугаар салбарын 10, мэргэжлийн ангийн 2, бүлгэмийн 20 хүн, нийт 90 ажилтан, албан хаагч, гал унтраах албаны 4 автомашинтайгаар зохион байгуулж, түлш 105 литр, бензин 15 литр, утаа гаргагч /Чаашиг/ 2 ширхэг, гал унтраах бодис /хөөс 190 литр, ус 3 тонн/ зарцуулж сургуулилт хийв.



2021 онд гал түймэр, тэсрэлт, галын зөрчилгүй ажилласан. ГАБ-ыг хангуулах зорилгоор гэрээт галын хэсэгтэй хамтарсан үзлэгийг давхардсан тоогоор 45 объектод галын үзлэгийг 2,600 удаа хийж, 1,633 зөрчил илрүүлж, 1,632 зөрчлийг арилгуулсан. Гарсан зөрчлүүдийг ангилж үзвэл: оч хаялт-420, шатах шингэний гоожилт-877, тоосролт-296, халалт-45, утаажилт-78, тоосны шатлага-7 байв. 2021 онд 12 нэр төрлийн 148 ширхэг галын аюулгүй байдлыг хангах анхан шатны

багаж хэрэгсэл нийлүүлэгдсэнийг цех, хэсгүүдэд хуваарилж анхан шатны багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангав. 2021 онд гал түймэр, галын зөрчилгүй ажилласан. ГАБ-ыг хангуулах зорилгоор гэрээт галын хэсэгтэй хамтарсан үзлэгийг давхардсан тоогоор 45 удаа, объектод галын үзлэгийг 2,600 удаа хийж, 1,633 зөрчил илрүүлж, тухай бүр нь зөрчлийг арилгуулж *Гамшгаас хамгаалах ажлын талаар:*

-“ДЦС-3” ТӨХК-ийн “Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб” болон мэргэжлийн ангиудын бүрэлдхүүнд шинэчлэгдсэн томилгоо хийгдсэн тул 2021 оны 05-р сард Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийн Гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулав.

-Галын аюулгүй байдлын тухай хууль, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, Галын аюулгүй байдлын хяналтын дүрэм, MNS 55:2019 стандартын хүрээнд мэдлэгийн шалгалтын тест боловсруулж, 2021 оны 04 дүгээр сарын 20-25-ны өдрүүдэд нийт 235 ИТА,ажилтнуудаас ГАБ-ын мэдлэгийн шалгалт авав.



✓ ТАД-ийн шалгалт өгч байгаа ажилчдад тогтмол галын анхан шатны мэдлэгийн болон галын унтраагууртай ажиллах зааварчилгаа өгч, зэрэг ахих, жинхлэх шалгалтанд нэмэлтээр ГАБ-ын талаар шалгалт авч ажиллав.

✓ Гамшиг, галын мэдлэг сэргээх сургалтын материал, стандарт, хууль, дүрмийн 8 мэдээллийг дотоод сүлжээнд байршуулж, сургалт сурталчилгаа хийв.

- ✓ Захиргаа, соёлын төв, тосны агуулахуудад галын үзлэг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулан хуучин гал унтраагууруудыг актлуулж, шинэ гал унтраагууруудаар нөхөн хангалт хийн галын анхан шатны 2 цэгийг шинээр бий болгож ажиллав.
- ✓ Станцын хэмжээнд цэнэггүй болсон гал унтраагууруудыг ажлын байрнаас хурааж, 12 нэр төрлийн 148 ширхэг галын анхан шатны багаж хэрэгслээр нөхөн хангалт хийв. Хөөсний бак №1-ийг ПО-1-6 маркийн 1.5 тн хөөсөөр цэнэглэв.
- ✓ Ковид-19 цар тахлын үеийн тодотгосон төлөвлөгөөг боловсруулж, удирдлагаар батлуулан ЭХЯ-ны хяналтын газар, ДҮТ-д албан бичгээр явуулав. Одоо тодотгосон төлөвлөгөөг мөрдөн ажиллаж байна.
- ✓ Сар шинэ угтсан, тамхины цэгийн тохижилт, усан хангамж, хуурайшилт, өвлийн үзлэг гэсэн удирдамжийн хүрээнд Галын хууль, дүрэм, стандартыг хангуулах үзлэгийг гэрээт галын хэсэгтэй хамтран цех, хэсгүүдээр тогтмол хийж ажилласны үр дүнд 2021 онд галын зөрчилгүй ажиллав.
- ✓ 2021 оны 04 дүгээр сарыг “Гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдлыг шалгаж, галын аюулгүй байдлыг хангаж ажиллах сар” гэсэн зорилт дэвшүүлж, үр дүнтэй ажил зохион байгуулав.

Эрүүл ахуй, халдвар хамгааллын талаар:

Орчны ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр

2021 оны ариун цэврийн комисс коронавирусийн халдварын улмаас цахимаар нийт 24 удаа хуралдан үзлэг шалгалт хийж, 58 удаагийн үүрэг даалгаврыг цех, нэгжүүдэд хугацаатай үүрэг даалгавар өгч гүйцэтгэлийг шалган зөрчлүүдийг арилгуулж ажиллав.

Бүх нийтийн хавар, намрын их цэвэрлэгээ, УБ хотын захирагчийн ажлын албанаас зохион байгуулдаг “Шарилжгүй Улаанбаатар аян 6” , ХУД-ийн нэрэмжит “Хоггүй Хан-Уул 2021” аянд нэгдэж, станцын хашаан дотор, гадна талбай нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн хог хаягдлыг цэвэрлэж, зориулалтын



хогийн цэгт тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэн хаяж зайлууллаа.

Үйлдвэрлэлийн эрүүл ахуйн чиглэлээр

Станцын хэмжээнд хэрэглэгдэж байгаа ундны усанд түүврийн аргаар нийт 6 цэгийн усны нянгийн болон ерөнхий химийн үзүүлэлтийг “Монгол Ус” ТӨҮГазрын Усны хяналтын төв лабораторид өгч шинжлүүлэхэд ундны усны ерөнхий химийн үзүүлэлт хэвийн, дээжнүүд тунгалаг ямар нэгэн хольцгүй, бага зэргийн гадны үнэртэй гэж гарсан. Монгол Улсын ундны усны чанарын шаардлагын стандарт болох MNS 0900:2018-тай нийцэж байна гэсэн дүгнэлт гарсан.

Цех, захиргаанд тавигдсан нийт 56 цэгийн ундны усны шүүлтүүрийг 2021 онд “СТАНДАРТ УС” ХХКомпанитай гэрээ хийн гэрээний хугацаанд суурин ундны усны шүүлтүүрийн гадна дотор угаалгыг өндөр даралтат уураар цэвэрлүүлж, 16.5 сая төгрөгийн солилт, засвар үйлчилгээ хийлгүүлсэн. Шинээр Засварын цехийн гал, химийн бригадын ахуйн өрөө, Цахилгаан цехийн ГШУ-1, ГШУ-2, ӨДЗуухан цехийн зуух цэвэрлэгээний бригадын ахуйн өрөө, ДДЗуухан цехийн Цит № 3,4, ДДТурбин цехийн ахуйн өрөө, Захиргаа нарийн бичгийн өрөөнд халуун хүйтэн усны төхөөрөмжийг гэрээт байгууллагаар нийт 7 ширхэг төхөөрөмж байрлуулж, ажилчдын ахуйн нөхцлийг сайжрууллаа.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 77-р тушаалын химийн хортой бодистой харьцаж ажилладаг нийт 162 ажилтанд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 171-р тушаалын дагуу хор саармагжуулах бүтээгдэхүүн болох Д витаминаар баяжуулсан 21,820 ширхэгийг сүү, энэ оны 5 сараас эхлэн тоостой нөхцөлд ажиллаж буй нийт 169 ажилтанд 14,194 ш хор саармагжуулах ундааг олгосон.



Нийслэлийн онцгой комиссын зөвлөмжийн хүрээнд коронавирус халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэрээт ариутгалын байгууллага болох “Дархинт” ХХК-иар захиргаа болон цех хэсэг нэгжүүдийн ажлын болон ахуйн өрөө, ариун цэврийн өрөө, цайны газар №1,2-нд ариутгал халдваргүйжүүлэлтийг сар бүр тогтмол хийлгүүллээ.

Харуулын шалган нэвтрүүлэх цэгийн рентген төхөөрөмжийн ажлын байранд сар бүр

цацрагийн хяналтын хэмжилт хийв.

Нийт ажилчдад ХАБЭА-н сургалт зохион байгуулах, шалгалт авах журмын дагуу “Осолдогсдод үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж”-ийн хичээл болох хиймэл амьсгалын дасгалыг төхөөрөмж дээр сургаж дадлагажуулах сургалт хийв.



Үйлчилгээ аж ахуйн хэсгийн бохирын үйлчилгээний ажилтнуудад “Ариутгалын бодисыг хэрхэн яаж хэрэглэх, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт сургалт явуулсан. Мөн хиймэл амьсгалын төхөөрөмж дээр анхны тусламжийн дадлагын хичээлийг Уурын хэсгийн 14 ажилтанд заалаа.

Харуулын шалган нэвтрүүлэх төв байранд аюулгүйн үзлэг шалгалтандаа 2012 онд үйлдвэрлэгдсэн Хятад улсын Shenzhen Security Electronic Equipment Co Ltd компанид үйлдвэрлэгдсэн аюулгүйн үзлэг шалгалтын рентген төхөөрөмж ашиглаж байгаа бөгөөд сар бүр тухайн ажлын

байранд тогтмол цацрагийн хяналтын хэмжилт судалгаа хийгдсэн. Хэмжилтээр зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй.

Ажилчдын цайны газрын хүнсний эрүүл ахуйн чиглэлээр:

Түрээсийн цайны газарт нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнсний чанар, стандарт, эрүүл ахуй, халдвар хамгааллын чиглэлээр хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдал, ажилдчын санал, гомдлыг харгалзан тухай бүрт нь хариуцах албан тушаалтанд мэдэгдэж эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллалаа.

Ажилчдын цайны газрыг ажиллуулж байсан “ЖИ ЭЙ ТИ И” ХХК-ын гэрээ дуусаж 2021 оны 03 дугаар сарын 15-наас эхлэн “ДБДМ” ХХКомпани түрээслэн ажилласан.

Ажилчдыг өдрийн хоолны цагаар бөөгнөрөл үүсгэхгүйн тулд тусгай цагийн хуваарь гаргаж, зай бариулах, гар ариутгах, ширээнд 2-оос илүү хүн суулгахгүй байхаар зохицуулалтыг хийж, ширээнд халдвар хамгаалалтаас урьдчилан сэргийлэх хаалт хийв. Мөн гар ариутгах хөл ажиллагаатай төхөөрөмжийг Засварын цехийн ажилчид санаачлан хийснийг байрлуулсан нь халдвар хамгааллын тустай ажил болсон.

Цайны газар №1, 2-т нийт 690м² талбайд сар бүр мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэж байна. Мөн станцын үйлчилгээний ажилтнууд өдөр бүр 17.00 цагт хоолны заал, талбайд халдваргүйжүүлэх уусмалаар тогтмол ариутгал хийж хонуулж тухайн өдрийн агаар дуслын халдварыг ариутгаж байна.

Халдвар хамгааллын дэглэм бариулж, цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар:

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор станцын төв шалган нэвтрүүлэх байранд биеийн халуун хэмжих, ариутгал хийх ухаалаг төхөөрөмж байрлуулж, ажтлдаа орж буй бүх хүмүүсийн халууныг хэмжиж, ариутгал хийж нэвтрүүлэв.

Хатуу хөл хорионы үеэр ҮААХ-ийн ажилчдад халдвар хамгаалалын иж бүрэн хувцас өмсүүлж, ээлжийн ажилчдыг зөөх автобусанд ариутгал халдваргүйтгэл хийлгэлээ.

Цех хэсгийн ажилчид өөрсдөө үйлдвэрлэлийн ажлын байр болон ахуйн байруудад ариутгалын бодис, жавелинтай ариутгалыг ээлжиндээ 2-оос доошгүй удаа хийж, ариутгалын бодистой цэвэрлэгээг тогтмол хийж ажиллаж байна.

Цех, нэгж, хэсгүүд ажилтнуудын биеийн халууныг ажлын байран дээр 2 цаг тутам хэмжиж байгаа бөгөөд ээлжийн ажилчид өглөө ажилдаа орох, орой ажлаасаа буухдаа халуунаа хэмжүүлэхээс гадна ажлын байран дээр 2 цаг тутам халуунаа хэмжиж, тэмдэглэл хөтлөн ажилчдын биеийн байдалд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Захиргаа болон цехүүдэд хэрэглэсэн бохир амны хаалтыг тусад нь хаях цэг бүхий хогийн савнуудыг байрлуулсан.

Ажилтнуудад гар угаах нөхцлийг бүрдүүлж, шингэн саван, халдваргүйжүүлэх уусмалаар хангасан. Ажлын байр болон ахуйн байрнуудын гар ариутгалын савнуудыг ариутгалын уусмалаар байнга цэнэглэж, ээлжийн даргын өрөөнд амны маск, ам зайлах сода, нэг удаагийн резинэн бээлий, спиртэн суурьтай ариутгалын уусмал, жавелиний уусмал зэргийг тавьж, ажилчдад амны хаалтыг тогтмол хэрэглүүлж ажиллаж байна.



Ажилчдыг олноор нь цуглуулахгүй, бөөгнөрөл үүсгэхгүй байлгах, хүн хоорондын 1.5-2.0 м зай барьж ажиллах талаар заавар, зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллаж байна.

Халдвараас урьдчилан сэргийлэх тухай мэргэжлийн байгууллагуудаас өгсөн заавар, зөвлөмж, мөн станцын эмнэлгийн хэсгээс өгч байгаа эмчийн заавар зөвлөмжүүд, анхааруулах зурагт хуудсуудыг бүх ажлын байрууд, өрөө тасалгаанууд, цех хэсгүүдийн мэдээллийн самбар, ариун цэврийн өрөөнүүдэд байршуулж, таниулан сурталчилах ажлыг тасралтгүй хийж байна.

Ариутгал, халдваргүйтгэлийг гэрээт “Дархинт” ХХК-иар тогтмол хийлгэж байна. Мөн нэгж хэсэг бүр өөрсдөө ариутгалыг эрүүл ахуйчийн өгсөн заавар, зөвлөмжийн дагуу ариутгалын төхөөрөмжөөр хийж байна. Мөн ажилчдын цайны газар №1, 2-ын нийт 690.0 м² талбайд клорсфитын уусмалаар ариутгалыг хийлгэлээ.



Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлээс хамгаалах зорилгоор цех, нэгж, хэсгүүдэд халдваргүйжүүлэлтийн бодис, хамгаалах хэрэгслийг жагсаалтын дагуу сар бүр олгон ажиллаж байна. Үүнд:

МУ-ын Засгийн газар 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн иргэдээ үе шаттайгаар короновирусын эсрэг вакцинд төлөвлөгөөний дагуу хамруулж эхэлсэн бөгөөд вакцинжуулалтад эхний ээлж 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдөр ХУДүүргийн 60-р сургууль дээр, хоёр дахь вакцинжуулалтыг 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр ХУДүүргийн ЭМТөвөөс компани дээр ирж 166 ажилтанг вакцинжуулалтад хамруулж станцын хэмжээнд нийт ажилчдын 86.0 хувь нь хамрагдсан.

Станцын хэмжээнд коронавирусийн халдвар эрчимтэй нэмэгдсэнээс үүдэн Гамшгаас хамгаалах орон тооны бус зөвлөлөөс коронавирусийн халдвар илрүүлэх зорилгоор Зоонозын үндэсний төвтэй хамтран нийт 3 удаагийн PCR шинжилгээнд нийт давхардсан тоогоор 767 хүнийг хамрууллаа.

14. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

“ДЦС-3” ТӨХК нь 2021 онд хоёр удаагийн тодотгосон төлөвлөгөөг оруулаад 21,648,947.8 мянган төгрөгийн нийт 143 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөснөөс 21,613,650.6 мянган төгрөгийн 136 нэр төрлийн худалдан авалтыг зохион байгуулж 20,731,751.1 мянган төгрөгийн гэрээ байгуулан болон шууд худалдан авч ажиллалаа. Худалдан авах ажиллагааны биелэлт нэр төрлөөр 143 худалдан авалт зохион байгуулахаас 136-г зохион байгууллаа. Хийгдээгүй 7 худалдан авалтын хувьд 5 нь авах шаардлагагүй дотоод нөөц бололцоогоороо хийсэн, 1 нь цар тахлын улмаас хийгдээгүй, 1 худалдан авалт төсөвт өртөг хүрээгүй шалтгаантай байна.

21,648,947.80 мянган төгрөгийн худалдан авалт зохион байгуулахаас 21,613,650.60 мянган төгрөгийн худалдан авалт зохион байгуулж гүйцэтгэл 99.8 хувьтай байна.

Бусад 136 тендерүүдийг амжилттай зохион байгууллаа. Тендерүүдийг хүчинтэй байх хугацаанд зохион байгуулан ажилласан. Тендер хүчинтэй байх хугацааг сунгуулсан ажил байхгүй болно. Худалдан авах ажиллагааны явцад зөрчил гараагүй болно.

2021 оны байдлаар Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт 1 тендерт гомдол гарсан. Тухайн гарсан гомдлын хувьд Мазут нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Интер стандарт нефть” ХХК-ийн гаргасан гомдлын дагуу “Сүүлийн 2 жилд жил тутамд санал болгож байгаа үнийн дүнгийн 100.0 хувьтай тэнцэх хэмжээний “Мазут” нийлүүлэх ажлыг гүйцэтгэсэн байх” гэснийг “Газрын тосны бүтээгдэхүүн” гэж өөрчил гэсний дагуу өөрчлөлт оруулан тендер шалгаруулалтыг үргэлжлүүлж хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдсэн. Сангийн яаманд гомдол гараагүй холбогдох хууль журмын хүрээнд ажилласан. 2021 онд 1,419,067.0 мянган төгрөгийн барааг дотоодоос худалдан авахаар

- ✓ “Жэй Эй Эйч” ХХК
- ✓ “ОРА Металл” ХХК
- ✓ “Як трейд” ХХК
- ✓ “МЭШ” ХХК
- ✓ “Координат эдвайс” ХХК
- ✓ “Батзорлого” ХХК
- ✓ “Төгс дардас” ХХК
- ✓ “Дашваанжил” ХХК
- ✓ “Би Цэ трейд” ХХК
- ✓ “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ
- ✓ “Резин эдлэл” ХХК
- ✓ “Термо базальт” ХХК
- ✓ “Мон сүү” ХХК
- ✓ “Глобал ацетилен” ХХК -иудтай гэрээ байгуулан ажиллалаа.

Тус станц нийт 143 худалдан авах ажиллагаа төлөвлөснөөс жилийн дүнгээр шууд худалдан авалт, гэрээ шууд байгуулах аргыг хасаад 90 тендер зарлахаас 89-ыг цахимаар зохион байгуулсан. Нээлттэй, харьцуулалт болон зөвлөхийн тендерүүдийг 98.9 хувийг цахимаар зохион байгуулсан байна. 1 тендерийн хувьд “Тунгаагдсан усны санд хуримтлагдсан үнс цэвэрлэх, засварлах” ажлыг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34.1.5-д заасан нөхцөл байдал үүссэн тул гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэсэн.

15. ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO 9001:2015 СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Бүтээмж, чанар дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд

2021 онд бүтээмж, чанарын баг дараах бүрэлдэхүүнтэй компанийн чанарын менежментийн тогтолцоо, бүтээмжийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажилласан. Үүнд:



Чанарын менежментийн тогтолцоо, бүтээмжийн дэд хөтөлбөр

- ✓ Эрсдлийн үнэлгээ хийх журам, аргачлал боловсруулж, батлуулах
- ✓ Дотоод аудитын журам боловсруулж батлуулах
- ✓ Процессийн эрсдлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээ төлөвлөх
- ✓ Нэгж хэсгүүдийн процессийн уялдаа холбоог сайжруулах
- ✓ Процессийн сайжруулалт хийх
- ✓ Эрсдлийг үнэлэх, баримт бичгийн бүртгэл хөтлөлтийг сайжруулах
- ✓ Чанар, бүтээмжийн мэдлэг сэргээх сургалтуудыг зохион байгуулах
- ✓ Саналын хайрцгаар ирсэн саналыг хүлээж авах, ангилах, үнэлэх хэрэгжүүлэх
- ✓ Ажлын байрны эмх цэгцийг сайжруулах, 5С-ийн аудит хийх
- ✓ ISO 9001 стандартын тохиролд дотоод аудит хийх зэрэг сайжруулалтын ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлсэн.



Ажлын соёл 5С хөтөлбөр

5С хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэлийн, оффиссын, ахуйн, нийтийн эзэмшлийн, гадна талбайн зориулалт бүхий 463 ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалт, өнгө үзэмжийг сайжруулах 5С-ийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.

2021 оны 5-р сарыг “Ажлын байрны эмх цэгцийг сайжруулж ажиллах сар” болгох зорилт тавьж ажилласан. 5С-ийн багт ХАБ-ын инженерүүд голлон ажиллалаа. 5С-ийн сайжруулалтын хүрээнд ажлын байрны аюулгүй байдал, эрсдлийг арилгахад чиглэсэн ажлууд голлон хийгдсэн.

5С-ийн багийн гишүүд нь 6 багт хуваагдан нэг баг нь 2 нэгж, хэсгийг хариуцан ажилласан.

5С-ийн хэрэгжилт /түвшин тус бүрээр/:



Ажлын соёл 5С хөтөлбөрийн хүрээнд 4С, 5С-ийн түвшинд хүрсэн ажлын байрны тоо жил бүр тогтмол нэмэгдэж байна. Ажлын байрны эмх цэгц 5С-ийг сайжруулах талаар

ажилтнуудын мэдлэг ойлголт жигд болсон. Гагцхүү хэвшүүлэх ажил нэгж, хэсгүүд дээр харилцан адилгүй байгаагаас хүрсэн түвшинг тогтоон барьж чадахгүй бууруулах хандлага ажиглагдаж байна.

Сайн саналын систем

Сайн саналын систем хөтөлбөрийн хүрээнд 2021 онд ажилтнуудын кайзен сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор “996 сайн санал, 996 сайн ажил, 996 эерэг дүн” сэдэвт аяныг үргэлжүүлэн зохион байгуулж, өмнөх жилийн амжилтыг ахиулах, хэрэгжсэн саналыг тоог нэмэгдүүлэхээр “Санаанаас сайжруулалт- Сайжруулалтаас амжилт” уриатай ажилласан.


2021 онд Сайн саналын баг 2 удаа цахимаар 2 удаа танхимаар хуралдаж ирсэн саналуудыг нэгтгэх, ангилах, үнэлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Саналын багт нийт:

716 санал ирсэн

278 санал хэрэгжсэн

Сайн саналын тоо сүүлийн 6 жилээр:



Өмнөх онтой харьцуулахад сайн саналын тоо 28.5 хувиар, хэрэгжсэн саналын тоо 18 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан олон нийтийг идэвхжүүлэх өдөрлөг, уулзалт, хурал цуглаан зэрэг арга хэмжээ зохион байгуулагдаагүй, ажилтнууд олон сар гэрээр ажилласантай холбоотой бууралт. 2021 онд захиргааны алба, хэлтсүүдийн саналын системд оролцох оролцоо өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн хандлагатай байна.



Чанарын дугуйлан хөтөлбөр

2021 онд Компанийн хэмжээнд бүртгэлтэй 18 чанарын дугуйлангаас 11 чанарын дугуйлан тогтмол ажиллаж, ажлын байрны эмх цэгц, ХАБ, тоноглолын найдвартай

ажиллагааг хангах чиглэлээр 19 төсөл, 21 сайжруулалтын ажлыг санаачлан хийж Чанарын дугуйлангийн хороонд тайлагнаж ажилласан.

Чанарын менежментийн тогтолцоо

Компанийн чанарын менежментийн тогтолцооны үр нөлөөг сайжруулж, ISO 9001:2015 стандартын магадлан аудитад шалгуулах, бэлтгэл хангах ажлын хүрээнд компанийн чанарын дотоод аудитын хөтөлбөрийг батлуулан аудитыг 3, 6 дугаар сард 2 удаа зохион байгуулсан.

ISO 9001 магадлан аудитыг Сингапурт төвтэй EGA IMC баталгаажуулалтын компанийн монгол дахь төлөөлөгч MSCS компанийн 4 хүний бүрэлдэхүүнтэй аудиторуд 9-р сарын 23-ны өдөр онлайнаар хийж гүйцэтгэсэн. Магадлан аудитаар 9 үл тохирол илрүүлж, 4 сайжруулах зөвлөмжийг өгсөн. Магадлан аудитын мөрөөр илэрсэн үл тохирлыг залруулах арга хэмжээний 21 ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг хангуулж ажилласан.

ISO 9001:2015 стандартын 4, 6-р бүлгийн шаардлага болох эрсдэлд суурилсан сэтгэлгээ хандлагыг бий болгох, эрсдлийн тухай ойлголт өгөхөд голлон анхаарч ажиллан компанийн Эрсдлийн үнэлгээ хийх журам, аргачлалыг боловсруулж батлуулсан.

Тус журам, аргачлалын дагуу нэгж хэсгүүдэд процессийн сайжруулалт, эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг өрнүүлж, нэгж хэсгүүдэд заавар, зөвлөмж өгч “Компанийн эрсдэл боломж, төлөвлөлт ба хяналт, процессийн уялдаа холбоо, чанарын бодлого, зорилт” сэдэвт 16 цагийн, “Дунд шатны удирдлагын манлайлал, оролцоо, ЧУТ-ны хэрэгжилтийн үр дүн, давуу тал” сэдэвт 8 цагийн сургалтуудыг тус тус цахимаар зохион байгуулж удирдлага, ИТА нарыг хамруулсан.

Эрсдэлийн үнэлгээний дагуу хариу арга хэмжээг төлөвлөж ТЗБАХ, бизнес төлөвлөгөөг боловсруулах ёстой. Уг ажилд удирдлагуудын идэвх оролцоо, уялдаа холбоог сайжруулах буюу нэгжүүдийн эрсдэлийн үнэлгээг компанийн хэмжээнд нэгтгэж дүн шинжилгээ хийх, байгууллагын хэмжээний эрсдэлийг тодорхойлох нь нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай ажил гэж дүгнэсэн.

Үүний дагуу Компанийн хэмжээний эрсдэл боломж, бодлого зорилтыг тодорхойлох процессийн хариуцагчийг дотоод журамд тусгаж өгөхөөр санал оруулсан.

16. НИЙГМИЙН АСУУДАЛД ЧИГЛЭСЭН АЖЛУУД

Компанийн дотоод журам, 2019-2020 онд Захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний дагуу компанийн ажилтан болон өндөр настан, ахмад, МШӨ-ний группийн хүмүүсээс ирсэн өргөдлийн дагуу буцалтгүй тусламж, хөнгөлөлт, нэмэгдэл, урамшууллыг олгож ажиллаж байна.

2021 онд ажилтнуудад тэтгэврийн тэтгэмж 29 хүнд 1,159.5 сая төгрөг, 38 хүнд буцалтгүй тусламж 97.1 сая төгрөг, орон сууцны дэмжлэгт нийт 111 ажилтанд 111.0 сая төгрөг, шагнал урамжуулалд 136 ажилтанд 51.9 сая төгрөг, Өндөр настан, МШӨ группт гарсан хүмүүст буцалтгүй тусламж 13 хүнд 20.3 сая төгрөг, цол тэмдгийн нэмэгдэл, гарын бэлэгт 532 хүнд 112.9 сая төгрөг тус тус олгож ажиллалаа.

Шагнал урамшууллын талаар

2021 онд нийт 139 ажилтан, өндөр настан ахмадуудыг төр засгийн одон медаль, МУ-ын Засгийн газрын шагнал, Монголын залуучуудын холбооны болон Монголын геологи, уул

уурхай, эрчим хүчний үйлдвэрчний эвлэлийн холбооны шагналуудаар шагнуулж урамшуулах, шагнал урамшууллыг гардуулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан.

Ажилчдын орон сууцны талаарх хийгдсэн ажил

Ажилчдын нийгмийн баталгааг хангах, тэдний өргөдөл гомдлыг барагдуулах, хууль ёсны эрх ашгийг хамгаалж хамтын гэрээг хэрэгжүүлэн ажиллаа. 2015 онд эхлүүлсэн “Эрчим” хотхоны төсөл гацаанаас гарлаа. Ажлыг эрчимжүүлэх зорилгоор байгуулагдсан ажлын хэсэг нь эрчимтэй ажиллаж, компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс тодорхой шийдвэр гаргуулан 154 ажилтны нийгмийн асуудлыг шийдэх энэхүү томоохон ажил гацаанаас гарч 2022 оны эхний хагас жилд ашиглалтанд орохоор болж байна.

Ажилчдын орон сууцны төлбөрийн асуудлыг шийдэх зорилгоор Хаан банкинд орон сууцны урт хугацааны зээл хүсэх, хамтран ажиллах тухай хүсэлт хүргүүлж шийдвэрлэсэн.

ХААН банкнаас зээл хүссэн ажилчдад 5 жилийн хугацаатай, сарын 1 хувийн хүүтэй орон сууцны зээлийг олгохоор шийдвэрлэж зээлэнд хамрагдах хүсэлтэй 64 захиалагч ажилчдын зээлийн материалыг бүрдүүлж шийдвэрлэгдсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22 –ны өдрийн 389 дугаар тогтоолоор “ДЦС-3” ТӨХК–ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 21 айлын орон сууцыг одоо амьдарч байгаа компанийн албан хаагчдад үнэгүй хувьчлах шийдвэр гарсан.

Шийдвэрийн дагуу орон сууц эзэмших эрхийн бичгийг 21 ажилтанд гардуулсан

17. ИЛ ТОД ЁС ЗҮЙН БАЙДАЛ

Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд МУ- ын засгийн газраас батлан гаргасан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”- ын дагуу зохих мэдээллийг тогтмол оруулж явсан.

Үүнд:

- Тендерийн урилгууд
- ХАА-ны төлөвлөгөө, тодотгосон төлөвлөгөө, тайлангууд
- Санхүүгийн тайлан, сар улирлын мэдээнүүд г.м

Компанийн үйл ажиллагааны мэдээллийг бүх ажилчдад ил тод, үнэн зөв, шуурхай хүргэх зорилгоор мэдээллийн цогц системийг тогтмол ажиллуулж байна. Үүнд:

- Дотоод сүлжээ
- Мэдээллийн самбар
- Компанийн цахим хуудас
- Компанийн facebook хуудас, групп, телеграм

КОМПАНИЙН 2021 ОНЫ ОНЦЛОХ ЗҮЙЛ

- 2021 онд техник эдийн засгийн үзүүлэлтүүдээ бүрэн биелүүлж 1,109.2 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, хэрэглэгчиддээ 927.6 сая кВт.ц цахилгаан эрчим хүч, 2,466.9 мян.Гкал дулааны эрчим хүч түгээж түүхэн дээд амжилтаа ахиулсан.



- Монгол улсын ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр компанийн үйл ажиллагаатай танилцахдаа тус станцын хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллахаа илэрхийлсэн.

- Улаанбаатар хотыг найдвартай эрчим хүчээр хангах зорилгоор станцын суурилагдан хүчин чадлыг өндөр даралтын станцыг 100 МВт-аар өргөтгөх, дунд даралтын станцыг 300 МВт-аар шинэчлэхээр 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр “ДЦС-3” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар ОХУ-ын ИНТЕРРАО-ЭКСПОРТ ХХК-ийн захирал М.Е.Сергеев нар Москва хотноо “ДЦС-3” ТӨХК ба “ИНТЕРРАО-ЭКСПОРТ” компанитай хамтран ажиллах тухай САНАМЖ БИЧИГ-т гарын үсэг зурж баталгаажуулсан.



- Шинээр 750 мян.м3 хүчин чадалтай шинэ технологи бүхий үнсэн сан барьж байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах зорилтынхоо хүрээнд технологийн усны схемийг өөрчлөн саарал усны ашиглалтыг 2 дахин нэмэгдүүлсэн.
- 2021 онд 128.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 108.1 хувиар биелүүлж, төлөвлөсөн алдагдлыг 3.5 тэрбум төгрөгөөр бууруулан Монгол улсын шилдэг 100 аж ахуйн нэгжээр дахин шалгарсан.

ДУГНЭЛТ

- Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 107.2 хувиар, түгээлтийн төлөвлөгөөг 108.2 хувиар, дулааны эрчим хүчний түгээлтийн төлөвлөгөөг 101.2 хувиар, диспетчерийн графикайг цахилгаанд 100.3 хувиар, дулаанд 100.0 хувиар биелүүлж үндсэн үүргээ САЙН биелүүлж ажиллалаа.
- Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчийг төлөвлөгөөт хэмжээнд барьж, жишмэл түлшний хувийн зарцуулалтыг цахилгаанд 4.4 гр/кВт.ц, дулаанд 0.4 кг/Гкал- аар тус тус хэмнэсэн.
- Нийт орлого төлөвлөснөөс 9,992.4 сая төгрөгөөр, нийт зардал 6,493.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, үндсэн үйл ажиллагаанаас 211.1 сая төгрөгийн, үндсэн бус үйл ажиллагаанаас 186.6 сая төгрөгийн, нийт 24.6 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан.
- Борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардлыг төлөвлөгөөт хэмжээнд барьж ажилласан.
- 2021 оны 12 дугаар сард ЭХЗХ-ноос чадлын тарифыг нэмэгдүүлснээр нийт авлага оны эцэст 16,479.7 сая төгрөгт хүрч төлөвлөгөөт хэмжээнээс 9,177.4 сая төгрөгөөр нэмэгдсэн. Үүнд “ДҮТ” ТӨХХК-иас авах авлага 13,882.9 сая төгрөгийг эзэлж байна. Нийт өглөгийн хэмжээ оны эцэст 30,403.1 сая төгрөгт хүрсэн. Үүнээс богино хугацаат өр төлбөрийн хэмжээ 13,151.9 сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 1,401.9 сая төгрөгөөр нэмэгдсэн. Энэ нь авлага өссөнтэй шууд хамааралтай.
- 2021 онд орон тооны гүйцэтгэлээр 989 гарч 7 орон тоогоор хэмнэж ажилласнаас цалингийн санг 0.5 хувь буюу 143.2 сая төгрөгөөр хэмнэсэн.
- 2021 онд компанийн техникийн бодлогын хүрээнд хийгдэж байгаа “Дулааны III цахилгаан станц” ТӨХК-ийн өндөр даралтын хэсгийн хүчин чадлыг 2х50 МВт-аар өргөтгөх, ДДС-ыг 2х150 МВт-аар шинэчлэх ажлын хүрээнд ОХУ-ын Интер РАО компанитай санамж бичиг байгуулж, төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу ажлын даалгаварыг шинээр боловсруулж гарган батлуулж гүйцэтгэгч компанид өгч ТҮШ, ТЭЗҮ боловсруулах ажлыг хийж эхлүүлсэн.
- 2021 онд ТЗБАХ, ХО-аар нийт 811,652.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ажлыг хийлгэсэнээр үндсэн тоноглолын галалгаа, зогсолтыг 9-р, тээрмийн салхилуурын ажлын хүрээм солих ажлыг 14-р бууруулж, дотоод хэрэгцээний ЦЭХ-ийг 980.0 мянган кВт.ц хэмнэж 245.5 сая төгрөгийн хэмнэлт гаргасан. Мөн Үйлдвэрийн уурын 19 хэрэглэгчийг 5 сар уураар хангах боломжгүй болох байсныг уурын түр шугамын зураг төсөв хийлгэн шугамыг зургийн дагуу угсруулж 614.2 сая төгрөгийн үйлдвэрийн уурыг түгээх нөхцөл бүрдсэн.
- Шинэ үнсэн сан барих ажлыг барилга угсралтын ажлыг бүрэн дуусгуулж ажилд залган саарал усны хэрэглээг нэмэгдүүлэн техникийн усны хэрэглээг төлөвлөгөөнөөс 562.7 мянган тн-оор, мөнгөн дүнгээр 39.8 сая төгрөг хэмнэсэн байна. 2020 оны мөн үеэс техникийн усны хэрэглээг 2.5 дахин бууруулж ажилласан.
- Станцын техникийн усны хэрэглээг хэмнэх, экологийн сөрөг нөлөөллийг багасгах техникийн усны хэрэглээг бууруулан тунгаах сангийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор саарал уснаас үнсийг ялган цэвэршүүлэх байгууламж барих угсралтын ажлыг эхлүүлсэн.
- Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөөний биелэлт 94.0 хувийн гүйцэтгэлтэй, гарсан үр ашиг нь жилийн дүнгээр 171.3 мян.кВт.ц цахилгаан эрчим хүчийг хэмнэсэн. Алдагдлыг бууруулж түлш, уур ус, эрчим хүчний хэмнэлт гаргах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, засварын зардлыг бууруулах талаар

ажлуудыг зохион байгуулснаар станцын хэмжээнд 294.4 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

2022 ОНЫ ЗОРИЛТ

1. Үйлдэрлэлийн аваар, осол, саатал, галын зөрчилгүй ажиллах
2. Эрчим хүчний үйлдвэрлэлийн төлөвлөгөөг биелүүлж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэн, өр авлагыг барагдуулж, зардал бууруулах
3. Техник эдийн засгийн үзүүлэлийг өмнөх оны түвшингээс бууруулахгүй байх
4. Үндсэн тоноглолын их засварыг графикт хугацаанд нь чанарын өндөр түвшинд хийж өвлийн их ачаалалд оролцуулах, их засвараас шалтгаалсан үндсэн тоноглолын зогсолт гаргалгүй өмнөх оны амжилтаа бататгаж ажиллах
5. Бараа материал, ажил үйлчилгээний тендер шалгаруулалтын ажлыг хуулийн хүрээнд, цаг хугацаанд нь зохион байгуулж ажиллах
6. Компанийн хэмжээнд сургалтын үйл ажиллагааг цахимжуулах, цахим сургалтын үйл ажиллагааг дэмжиж сургалтын оролцоо, хэрэглээг сайжруулан хүний нөөцийн чадавхийг сайжруулж ажиллах
7. Техник, эдийн засгийн үр ашигтай, байгаль орчинд ээлтэй төсөл хэрэгжүүлэх бодлого баримталж ажиллах
8. “Алсын Хараа-2050” бодлогын бичиг баримтын зорилтын хүрээнд Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүнтэй цахим засаглалыг төлөвшүүлж ажиллах
9. 2022 оныг “Ажлын байрны эрсдлийг бууруулж ажиллах жил” болгон зарлаж, улирал бүр зорилт тавьж ажиллана.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ТЭЗХ-Н ДАРГА

Л.ЭРХБААТАР

Л.ОЮУН-ЭРДЭНЭ